

БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөнгийн экологи ба хамгааллын талаар мэдээлэл солилцох 6 хэл дээрх хэвлэл

Saiga t. tatarica-ийн
морфологийн онцлогууд



Зургийг Виктор Малеев

Бөхөнгийн ангилал зүй

Дэвид П. Маллон

Байгаль хамгаалах олон улсын холбоо,
Туруутны мэргэжлийн багийн дэд-тэргүүн, d.mallon@zoo.co.uk

“Дэлхийн хөхтний зүйлүүд” номын гуравдахь хэвлэлд Монгол оронд тархсан бөхөнгийн дэд зүйл болох *Saiga tatarica*-г *S.borealis* гэсэн эртний сөнөж устаж алга болсон хэлбэрт хамааруулсан нь уламжлалт ангилал зүйд ихээхэн анхаарал татаж байв (Wilson & Reeder 2005). Энэ өөрчлөлт нь маргаантай байдалд байна.

Зүйлийн ангилал зүй нь ялгаатай хэлбэрүүдийн хоорондох харилцаа хамаарал, эволюцийн түүхийг аль болох тодорхой ойлгоход төдийгүй түүнчлэн ДБХХ-ны Улаан данс, Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци (CITES)-ийн хавсралт болон бусад холбоотой хууль эрх зүйн акт, Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенци (CMS), олон улсын болон үндэсний түвшинд мөрдөгддөг бусад хууль эрх зүйн актан д нэгж болгон ашиглахад практикийн ач холбогдолтой. Дэлхийн, бүс нутгийн, орон нутгийн түвшинд зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай хамгаалалтын орчинд зүйлүүд өргөн ашиглагддаг. Бөхөнгийн ангилал зүйг тойрсон нөхцөл байдлыг тодорхой болгох зорилгоор сүүлийн үеийн зарим судалгааны үр дүнг энд нэгтгэн харуулав.

Олонх зүйлийн нэгэн адил бөхөн нь хэд хэдэн нэрээр, тухайлбал *S.imberbis* гэх мэтээр нэрлэгдэж байв. Энэ нэршлийг хүчингүй болгон *Saiga tatarica* Linnaeus, 1766 гэсэн шинжлэх ухааны нэршилтэй болгосон билээ.

Анх Банников (1946) Монгол орны бөхөнг үсний өнгө, эврийн хэмжээ, хэлбэр, гавлын ясны хэмжилтийн ялгаан дээр үндэслэн *Saiga mongolica* буюу бие даасан зүйл гэж тодорхойлсон. Гэсэн хэдий ч тэрээр удалгүй өөрийн дүгнэлтийг засварлан, *S. imberbis mongolica* [= *S. tatarica mongolica*] гэсэн дэд зүйлд хамруулсан (Банников 1954).

Ийнхүү өнөө үед оршин буй 2 дэд зүйл (*S. t. tatarica* болон *S. t. mongolica*), (Ellerman болон Morisson-Scott 1951, Гептнер нар. 1961, Соколов 1974, Корбетт 1978, Соколов & Жирнов 1998) мөхөж устсан 3 дэд зүйлүүд болох-*S.t.borealis*, *S.t.prisca* ба *S.t.binagadensis* гэсэн ангиллыг (тухайлбал Соколов нар 1998) бараг бүх судлаачид мөрдөж ирсэн.

Холодова нар (2006) одоо мөрдөж буй бөхөнгийн зүйлийн энэ ангиллыг нотолсон генетикийн баталгааг гаргаж ирсэн. Тэд өнөө үед оршин буй бөхөнгийн 5 популяциас (Казахстаны 3, ОХУ-ын 1, Монголын 1 популяци) 93 эсийн дээж цуглуулан митохондрийн ДНХ-г судалсан.

Судалгааны үр дүнд “...*S. t. mongolica* and *S. t. tatarica*-ийн хоорондох өчүүхэн, гэхдээ тодорхой ялгаанууд нь бие даасан

Үргэлжлэл 2-р хуудсанд.

Энэ хэвлэлийг ивээн тэтгэсэн:

АГУУЛГА

Гол мэдээ

Дэвид П. Маллон Бөхөнгийн ангилал зүй 1

Сүүлийн үеийн мэдээ

Стефан Зутер Казахстан, Узбекистаны хил дагуу хилийн тор татах ажил 3

Стефан Зутер Бетпак-Далагийн популяцийн их хэмжээний үхэл хорогдол 4

Юрий Грачев Казахстанд 2012 онд хийгдсэн агаарын судалгааны үр дүн 4

Наташа Шивалдова Каракалпакстаны сургуулийн хүүхдүүдэд зориулсан сургалтын шинэ хөтөлбөр 5

Елена Быкова, Бердияр Жоллибеков болон Надежда Арылова Бөхөнгийн өдөр 2012 6

Фенглиан Ли Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн Өмнөд Хятадын төслөөс анхаарал хандуулж буй бөхөн 9

Севара Шаранова Биологийн олон янз байдал ба хий, газрын тосны үйлдвэрлэл 9

Соня Розенфелд Шувуу судлаачид бас бөхөнд дуртай 10

Александр Клепалов Алтан ахууна бөхөнг аюулаас ангижруулах болно 10

Занна Аксартова Хууль бусаар бөхөнгийн эвэр худалдаалахын эсрэг мэдээллийн кампанит ажил эхэллээ 11

Хэвлэлийн мэдээ

Казахстан-Узбекистаны хил дагуу тор татах ажлын талаарх сүүлийн үеийн мэдээ 12

Бөхөнгийн эврийн худалдаалах явдлын эсрэг Кызылордагийн цагтаагийн хэлтэсээс хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд
Ус уух газар бий болгох нь Казахстаны бөхөнгийн тоо толгой өсөхөд тустай

Бөхөн хамгаалах цахилгаан хашаа

Амьтны эрүүл мэндийн олон улсын сан (IFAW) бөхөн хамгаалахад Орост туслах болно

Бөхөн агнасан болон хууль бус худалдааны хэргүүд

Өгүүлэл

Баярбаатар Бүүвэйбаатар нар.
Монгол орны бөхөнгийн янзаганы мэнд үлдэлтийн болон орон зайн экологи 15

Грэхэм Эллиот нар.
Пре-Каспийн бүс нутгийн бөхөнгийн амьдрах орчны ашиглалтыг үнэлэхэд хамтын оролцооны мониторингийн аргыг ашиглах 16

Петр Дамерелл нар.
Устюртын тал нутгийн хүрээлэн буй орчны боловсролд анализ хийх нь 17

Элия Телкараева
Иргэз-Тургай-Зыланшик бүс нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ 19

Е.Ж.Милнер-Гулланд
Устюртын тал нутагт баригдаж буй хилийн торны хэрэгжилтийн явц, бөхөн гөрөөсийг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах боломжууд 20

Бөхөнгийн баатрууд

Аркадий А. Слудский, Казахстан 22

1-р хуудасны үргэлжлэл:

зүйл гэхээсээ илүүтэйгээр одоогийн *S. t. mongolica* гэсэн дэд зүйлийн тодорхойлолтыг баталж байна” гэж дүгнэжээ.

Барышников, Тихонов нар бөхөнгийн устаж үгүй болсон хэлбэрүүдийг судалсан бөгөөд Якутаас цуглуулсан дээжийн хоорондох ялгаан дээр үндэслэн *S. borealis*-г бүрэн бие даасан зүйл болох тухай санааг дэвшүүлсэн. Мөн тэд энэхүү ангилалзүйн хэлбэр нь Монголд тархаж буй *S. borealis mongolica* болохыг баталсан (өөрөөр хэлбэл Монголд тархсан хэлбэр нь *tatarica* биш, *borealis* болохыг тодорхойлсон). Грубб (2005) “Дэлхийн хөхтний зүйлүүд” номонд энэхүү дүгнэлтийг оруулснаар олон нийтэд илүү их хүлээн зөвшөөрөгдөж эхэлсэн.

Гровес ба Грубб нарын (2011) туруутны ангилал зүйд хийсэн засвар нь Банниковын нийтлүүлж байсанчлан Монгол бөхөн нь *Saiga mongolica* болохыг нотолсон. Гэхдээ тэд (1) Банников өөрийн гаргасан дүгнэлтийг засварласан болон (2) Холодова нарын (2006) генетик нотолгоо, баримтыг тооцоогүй байна. Гровес ба Грубб нар (2011) өнөөгийн туруутан амьтны зүйлийн жагсаалтыг үндэслэн Дэлхийн Хөхтний гарын авлага номыг бичихэд ашигласан (Wilson ба Mittermeier 2012).

‘*S. borealis*’-н хоёр хэлбэрийг хамруулан бөхөнгийн тархац нутгийн бүх хэсгээс одоогийн оршин байгаа бөхөнгийн 38 дээж, эртний мөхөж устсан хэлбэрийн 27 дээжийг тус тус цуглуулан митохондрийн ДНХ-г ашиглан одоо оршин байгаа болон мөхөж устсан хэлбэрүүдийг судалсан Кампос нарын (2010) онд хийсэн сүүлийн үеийн генетик судалгаагаар *S. borealis* нь бие даасан зүйл гэж батлагдаагүй юм. Судалгааны үр дүн бөхөнгийн 2 үндсэн уг гарвал байгааг харуулсан бөгөөд эхнийх нь Якутын зүүн хойд хэсгээс Урал хүртэлх одоо оршин байгаа болон эртний мөхөж устсан бүх хэлбэрүүдийг хамруулсан байна. Харин хоёрдах нь зөвхөн Уралын хойд хэсэгт тохиолдох бөгөөд мөхөж устсан хэлбэр юм. Судлаач “...судалгааны мэдээлэл нь *S. borealis* илт ялгаатай дэд зүйл эсвэл зүйл гэж тогтоогдоогүйг харуулж байна” гэж дүгнэжээ. Цаашилбал, уг судалгааг гүйцэтгэгчидийн энэхүү өөрчлөлтийг 1994 оны өгүүллийг бичсэн Барышников болон Тихонов, мөн бусад судлаачид дэмжиж байв.

Холодова нарын (2006) хийсэн генетик анализ нь монгол бөхөн нь *S. tatarica*-гийн дэд зүйл болохыг баталсан бол Кампос нарын (2010) сүүлийн үеийн судалгааны үр дүн одоо амьдарч байгаа болон мөхөж устсан бүх хэлбэр нь *S. tatarica* болохыг харуулсан. Иймээс зөв дүгнэлт нь өнөөгийн монгол бөхөнгийн шинжлэх ухааны хамгийн оновчтой зөв нэр нь *Saiga tatarica mongolica* Банников, 1946 байх ёстой.

Сүүлийн үеийн бүх судалгааны үр дүнд Монгол бөхөн нь *S. t. tatarica*-аас генетикийн хувьд үл ялиг ялгаатай боловч гавлын ясны хэмжилт,



Монгол бөхөнгийн морфологийн онцлог
(*Saiga t. mongolica*)

эврийн хэмжээ, хэлбэр болон биеийн өнгө, экологийн хувьд илүү их ялгаатай болохыг харуулж байна. Дээрх хоёр генетикийн судалгаа нь *mongolica* бол дэд зүйл байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Гэсэн хэдий ч, генетикийн

судалгаа нь одоогийн байдлаар Монгол орны харьцангуй цөөн тооны дээжээс зөвхөн митохондрийн ДНХ-г ялгах замаар хийгдэж байна. *Saiga tatarica* болон *mongolica*-н хоорондох филогенетикийн уялдаа холбоог шийдвэрлэх арга замыг бий болгоход их хэмжээний дээжтэй байж, бөөмийн ДНХ-ийг ашиглан цаашдын анализыг хийх нь илүү үр дүнтэй байх болно. Хэрвээ уг судалгаагаар зүйлийн түвшний ялгааг харуулбал зөв нэршил нь *S. borealis* биш, *S. mongolica* байхыг амьтан судлалын шинжлэх ухааны нэршлийн дүрэм нотолно.

Редакторын тэмдэглэл: Ашигласан бүтээлийн дэлгэрэнгүйг авахыг хүсвэл зохиогчтой холбогдоно уу.

Сүүлийн үеийн мэдээ

Казахстанд 2012 онд хийгдсэн агаарын судалгааны үр дүн

Юрий А. Грачев, Амьтан судлалын хүрээлэн, Казахстаны БНУ, teriologi@mail.ru

Казахстаны бөхөнгийн агаарын судалгааг 2012 оны 4 сарын 8-наас 26-ны хооронд Казахстаны Амьтан судлалын хүрээлэн, Казахстаны БНУ-ын Хөдөө Аж Ахуйн яамны Ой ангийн хэлтэс, Улсын Охотзоопром байгууллага, Ой, ангийн менежментийн ой ангийн бүс нутгийн байцаагч нар, Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, “Зэрлэг амьтдын судалгаа ба хөгжил” болон “Амьтны аймаг” компаниуд оролцон гүйцэтгэлээ.

Судалгааны үр дүнгээр Казахстаны бөхөнгийн тоо толгой 137500 толгой (2011 онд 102000) гэж үнэлэгдсэн бөгөөд үүнээс Бетпак-Далагийн популяцид 110000, Устюртийн популяцид 6500, Уралын популяцид 21000 толгой бөхөн байна. 2011 оны үр дүнтэй харьцуулан үзвэл Бетпак-далагийн популяци 41%-иар, Уралийнх 11%-иар, Устюртийнх 6,5%-иар тус тус өссөн байна. Нэмэлт мэдээллийг автортой холбогдон авна уу.

Казахстан, Узбекистаны хил дагуу хилийн тор татах ажил

Стефан Зутер, КБТЗХН, steffen.zuther@acbk.kz

Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг 2012 оны хавар бөхөнгийн хэвийн нүүдлийг хязгаарлах хүчин зүйл болдог түүнчлэн хууль бус агнуурын тааламжтай нөхцлийг бүрдүүлэх хилийн тор татах ажил Казахстан, Узбекистаны хилийн Устюртын тал нутагт хийгдэх тухай мэдээллийг хүлээн авсан. Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгийнхэн Казахстаны БНУ-ын ХАА-н яамны Ой ангийн зөвлөлтэй холбогдон Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн тавьсан хүсэлтэй адил утга бүхий хийгдэж буй бүтээн байгуулалтын тухай албан ёсны мэдээлэл авахыг хүссэн.

Жил бүх олон тооны бөхөнгүүд хойд зүгт өөрсдийн зуны бэлчээр болон төллөдөг газраа хүрэхээр, мөн өвлийн бэлчээртээ хүрэхээр урагшаа чиглэн энэ хилийг хөндлөн огтлон гардаг бөгөөд хилийн торон хашаа үүнийг хязгаарлах болно. Туйлын эмзэг нөхцөлд байсаар байгаа Устюртын бөхөнгийн популяцид тэдгээрт учруулах нөлөөг урьдчилан




Зураг 1. Амьтан судлалын хүрээлэнгийн зөвлөж буй коридор

харах боломжгүй юм.

Ой ангийн зөвлөл холбогдох хил хамгаалах албатай зөвлөлдөн, Орос, Беларус, Казахстаны хоорондох шинээр байгуулагдсан гаалийн холбооны Гадаад хилийг хүчирхэгжүүлэх хөтөлбөрийн дор байгуулагдаж буй хилийн тор татах ажлын талаар мэдээлэл авсан. Бөхөнг чөлөөтэй нүүдэллэх боломжийг хангахын тулд хил дээр нээлттэй корридор байгуулах талаар зөвлөмжийг Амьтан судлалын хүрээлэн өгсөн (Газрын зураг 1).

Ой ангийн зөвлөл Устиортын бөхөнгийн популяцид энэ асуудал чухал ач холбогдолтой болохыг ойлгож байгаа бөгөөд тэд зэрлэг амьтдад ээлтэй тор, нүүдлийн замын загварчлалын талаарх бусад орнуудын туршлагыг судлахаар сонирхож байна.

Хашааг барьж гүйцэхээс өмнө буюу 2011-2012 оны өвөл Олон улсын амьтан ургамлын аймаг (FFI), Казахстаны бөхөн хамгаалах нийгэмлэгээс хэрэгжүүлж буй “Устиортын ландшафт хамгааллын санаачлага” төслийн багийнханы сансрын дохиолол зүүж тавьсан бөхөн хил дамнан нүүдэллэсэн байна (Зураг 2). Олон улсын ургамал амьтны аймаг, Казахстаны бөхөн хамгаалах нийгэмлэгийнхэн дохиолол бүхий хүзүүвч зүүх замаар энэ асуудлыг хянах ажлаа үргэлжлүүлэх болно.




Зураг 2. Казахстан, Узбекистаны хоорондох хилийн торон хашаа ба хүзүүвч зүүсэн 2 бөхөнгийн улирлын шилжилт хөдөлгөөн

Бетпак-Далагийн популяцийн их хэмжээний үхэл хорогдол

Стефан Зутер, КБТЗХН, steffen.zuther@acbk.kz

Казахстаны Костанай мужийн өмнөд хэсэгт Бетпак-Далагийн популяцийн гол төллөгч газрын ойролцоо, Зангелдинский дүүрэгт 2012 оны Усарын 19-нөөс 25-ны хооронд бөхөн олон тоогоор үхэж хорогдсон явдал гарсан. Энэхүү олон тоогоор үхэж хорогдсон явдал нь Баруун Казахстаны Уралын популяцид 2010 болон 2011 онд ажиглагдсан үзэгдэлтэй ижил төстэй 3 дахь

тохиолдол болсон. (Бөхөнгийн мэдээ 11, 13, 14-аас хар). 2012 онд нийт дүнгээр 926 бодгаль үхсэний 759 нь эм, 19 нь эр, 148 нь янзага байсан. Бөхөн төллөсний дараа дээрх үхэл хорогдол ажиглагдсан. Тэнд ямар нэгэн тодорхой өвчин эмгэг ажиглагдаагүй.



Зураг 1. 2012 онд бөхөн үхсэн газрын байршил

Бөхөнгийн өвчин судлах төрийн санхүүжилт бүхий 3 жилийн судалгааны хөтөлбөрийн нэг хэсэг болох тухайн нутаг дахь төллөлтийн био аюулгүй байдлын мониторингийг Үндэсний судалгааны төв Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр аль хэдийнэ хийсэн болно. Хэдийгээр мониторинг хийх явцад тодорхой өвчний шинж тэмдэг ажиглагдаагүй ч цуглуулсан мэдээллийн анализ нь үхлийн шалтгааныг тодорхойлох мэдээлэл өгч магадгүй юм. Хэд хэдэн их дээд сургууль олон тоогоор бөхөн үхсэн үзэгдлийг судлахад оролцсон. Торгай, Костанай, Астана, болон Алматыгаас ирсэн малын эмч нар үхлийн шалтгааныг тодорхойлох хээрийн судалгаанд оролцлоо. Улсын байгууллага болох “Охотзоопром”-ын олон байгаль хамгаалагч нар, түүнчлэн КБТЗХН-ийн байгаль хамгаалагчид болон Ой ангийн хорооны төлөөлөгч нар оролцов. Ой ангийн хороонд хүргүүлсэн албан ёсны баримтаас үзвэл үхлийн шалтгаан нь пастероллез байсан. Үхсэн амьтдыг шатаасан бөгөөд ажиглалтууд явагдаж байна.

Каракалпакстаны сургуулийн хүүхдүүдэд зориулсан сургалтын шинэ хөтөлбөр

Наталья Шивалдова, Econews.uz, nshivaldova@mail.ru

Цөөн хэдхэн жилийн өмнө бөхөнгийн нүүдэл Узбекистаны Устюртын тал дахь тосгоны ойролцоо өнгөрдөг байсан бөгөөд хатуу ширүүн өвлийн улиралд заримдаа амьтад тосгон руу орж ирдэг байв. Харин одоо бол хүмүүсийн ойролцоо бөхөнг хэзээ ч олж харахгүй ба тэд уг нутгийн хүрэхэд хэцүү, хүний хөлөөс алс бөглүү газар, гэхдээ тэдний гол дайсан болох-тал нутагт энд тэндгүй сарнин тархсан тосгодоос ирэх хулгайн анчид очиж чадах нутагт идээшин байршиж байна.

Устюрт нутгийн оюутнууд, багш нар, оршин суугчид бөхөнд хэрхэн тусалж чадах вэ? Хүүхдүүд хулгайн анчдыг тогтоон барихад хувь нэмрээ оруулж чадахгүй. Гэсэн хэдий ч эдгээр харгис хэрцгий хулгайн анчид нэгэнтээ сургуулийн хүүхэд байж, өөрсдийн гэр бүлтэй байсан. Хүүхдүүдэд шинэ мэдээлэл шаардлагатай байгаа бөгөөд байгаль дэлхийн ашиглалтын хандлага, бүдүүлэг зан авирын стереотипыг ялан дийлэхийн тулд тэдгээр хүүхдүүдтэй ажиллах нь үнэхээр чухал юм. Энэ нь хүүхдүүдэд бөхөнгийн тухай аль болох боломжит бүх мэдээллийг өгч, тэдний төрөлх тал нутагт идээшин амьдарч байгаа энэхүү цорын ганц туруутнаар бахархах ёстойг ойлгуулахад чухал ач холбогдолтой.

оролцсон. Тэд сурагчдад зориулсан сурах гарын авлага, багш нарт хичээлийн гарын авлага, боловсрол олгох хөлөгт тоглоом, бөхөнгийн биологи, тал хээрийн экосистемийн тухай зурагт үзүүлэн зэрэг “Бөхөн-байгалийн гайхамшигт бүтээл” сэдэвт хичээлийн багцыг авчирсан.



Зургийг Александр Естинов

Семинарт оролцогсад мэдлэг олгох зурагт үзүүлэнг хэлэлцэж байна.

Энэхүү хичээлийн багцыг Бөхөн хамгаалах нийгэмлэгт зориулан Узбекистаны БНУ-ын байгаль хамгаалах төрийн зөвлөл Дисней-Канада сангийн Пингвин клубийн дэмжлэгтэйгээр бэлтгэсэн билээ. Уг хичээлийн багцыг багш нар халуун дотноор хүлээн авсан бөгөөд сургалтын семинар нь маш их сэтгэл хөдлөлийн дор явагдсан. Багш нар маш их хүсэл тэмүүлэлтэйгээр энэхүү баярын үйл ажиллагаанд бэлдэх, хэрэгжүүлэхэд хамтран оролцсон. Тухайн экологийн санаачлага нь орон нутгийн эрх баригчдаас мөн дэмжлэг хүлээн авсан. Энэ боловсролын хөтөлбөрийн эхлэл нь Узбекистаны бөхөн хамгаалах талаар хийгдэж буй томоохон хүрээтэй ажлын нэг хэсэг болох хулгайн анг бууруулахад чиглэгдсэн.

Энэ бүх үр дүнг үл тоон, хавар цас хайлсаны дараа хүмүүс өөрсдийн дур сонирхол, уламжлалын дагуу хялбар ашиг олохын тулд бөхөнг хайн тал нутаг руу явсаар байна.



Зургийг Александр Естинов

Наталья Шивалдова Жаслык тосгоны багш нартай хамт

Иймд багш нар хүүхдүүдийн дэлхий ертөнц рүү хөтлөх гүүр болох бөгөөд уламжлалт багшлах арга хэрэгсэл нь тэдний сурч боловсрох, илүү их сонирхлыг төрүүлэхэд тэдэнд туслах нь үүний салшгүй хэсэг юм. Бөхөнгийн өдөрт бэлтгэх ажлын нэг хэсэг болгон бид 4 сарын 4-8-ны өдрүүдэд орон нутгийн нөхөрлөлүүдийн төлөөлөл, Жаслык, Каракалпакя, Кырк-Кыз тосгоны дунд сургуулийн багш нартай хамтран уулзалт, семинар зохион байгуулсан. Уг багт Узбекистаны ШУА-ийн экологичид, Бөхөн хамгаалах нийгэмлэгийн төлөөлөгчид, залуу үеийн сурган хүмүүжүүлэх салбарт ажиллаж байсан туршлагатай багш нараас



Зургийг Наталья Шивалдова

Кырк-Кыз тосгоны семинарт оролцогсад

Зах зээл дээр бөхөнгийн мах байсаар байгаа нь үүний эмгэнэлт нэгэн нотолгоо юм. Устюртын өргөн уудам тал нутгаар тосгоноос тосгон руу явах зуураа та өөрийн бодолдоо бусад зүйлийн талаар тунгаан бодож эхлэнэ. Надад “*бөхөнг үргэлж буудаж алдаг ойролцоо орших бүх хулгайн анчид алга болох үед тэнд агнах ямар ч амьтангүй болсон байх болно. Хэрвээ тал нутагт бөхөн байхгүй бол хэн ч дахин агнахгүй, хэн ч сурч боловсрохгүй болно*” гэсэн ийм нэгэн утгагүй хачин бодол төрж байсан. Хэрвээ бүхэл бүтэн экосистем хөзрөн байшинтай адил нуран унавал тал нутаг мөхсөн сарны гадаргуутай адил амьдралгүй орон зай руу аажмаар шилжих болно. Бөхөн бол тал хээрийн болон эндхийн бүх оршин суугчдын амьдрах хүсэл тэмүүлэл юм. Энэ бол олон талт тал хээрийн

экосистемийг сэргээх боломж юм. Ядахдаа бөхөнд эсэн мэнд үлдэх бага ч атугай боломж өгөх ёстой ба ингэвэл тэдний төрөлхийн уян хатан чанараас шалтгаалан түргэн хугацаанд нөхөн сэргэх болно. Харамсалтай нь энэ боломж нь хүрээлэн буй орчныг хамгаалагчдын эрч хүч дүүрэн, илүү их эрчимтэй үйл ажиллагаанаас хамаарна...

Редакторын тэмдэглэл: Хэрвээ та Орос хэл дээрх (электрон хувилбар) Каракалпаккийн багц хичээлийн (электрон болон цаасан хэлбэрээр) хувийг сонирхож байвал Елена Быкова руу esipov@xnet.uz хаягаар хандана уу.

Бөхөнгийн өдөр 2012

Бөхөнд зориулсан экологийн энэхүү баяр нь Узбекистан, Казахстан, ОХУ-ын сургуулиудад сайхан уламжлал болон тогтжээ. Хүүхдүүд болон насанд хүрэгчид энэ үйл ажиллагааг хүсэн хүлээдэг. Байгаль руу илүү их анхаарал хандуулсан үйл ажиллагааг дэмжин, боловсрол болон мэдээллийг түгээх үр дүнтэй арга хэрэгслийн сайн жишээ нь Бөхөнгийн өдөр юм.

Узбекистан дахь бөхөнгийн өдөр

Елена Быкова, Бөхөн хамгаалах нийгэмлэг, esipov@xnet.uz

Жаслык болон Каракалпакия тосгод Узбекистанд энэ үйл ажиллагааны санаачилгыг хэрэгжүүлэх газар болдог бөгөөд энэ жил Кырк-Кыз тосгон тэдэнтэй нэгдсэн. Орон нутгийн засаг захиргаа, Бөхөн хамгаалах нийгэмлэг, Узбекистаны байгаль хамгаалах төрийн зөвлөлийн дэмжлэгтэйгээр сургуулиудын дунд зохион байгуулсан энэхүү үйл ажиллагаанд сургуулийн хүүхдүүд, насанд хүрэгчид, цэцэрлэгийн хүүхэд нийлсэн зуу гаруй хүн оролцсон.



Зургийг Александр Есипов

Тоглолтонд хөтөлбөрт багтсан бяцхан оролцогчид

Орон нутгийн дөрвөн сургууль дээр зохион байгуулагдсан уг баяр нь сонирхолтой концерт, асуулт хариултын уралдаан, спорт болон урлагийн тэмцээнээр эхэлсэн. Уг баяр нь сургуулиудын доторхи бөхөнгийн тухай хичээлүүдийг хамарсан экологийн сэдэвд илүү ач холбогдол өгсөн. Бөхөн хамгаалах нийгэмлэг хамгийн сонирхолтой, гайхалтай хичээл бэлдсэн таван шилдэг багшид шагнал өгсөн. Жаслык тосгоны 8, 9-р ангийхны дунд зургийн уралдааныг маш амжилттай зарлан явуулсан нь уг үйл ажиллагааны хамгийн сэтгэл догдлуулсан хэсгийн нэг байсан. Эхний ээлжинд хүүхдүүд сургуулийн хашаанд удаан хугацаагаар хадгалагдан зөвэнд идэгдэж хэрэглээнээс гарсан хий дамжуулах хоолой дээр зураг



Зургийг Александр Есипов

Хүүхдүүдийн хийсэн бөхөнгийн тоглоомууд

зурж чимэглэсэн. Энэ бүхний эцэст уг хоолой зөвхөн сургуулийн хашааг төдийгүй тосгоныг бүхэлд чимсэн жинхэнэ урлагийн бүтээл болон хувирсан.



Зургийг Александр Есипов

Зургийн тэмцээн

Жаслык тосгоны оршин суугчдын нэг: “Бидний нүдэн дээр залуус өөрсдийн гараар муухай зүйлийг гоё сайхан болгон хувиргаж байна! Энэ бол томчуулын туслалцаагүйгээр өөрсдийн хүрээлэн буй орчныг өөрчилж буй анхны тохиолдол юм” гэж дүгнэсэн. Сурагчид тал хээрийн туруутны талаарх өөрсдийн мэдлэгээ

өргөжүүлээд зогсохгүй тэд өөрсдийн төрөлх газар нутгаа хамгаалахад ямар нэгэн ашигтай зүйлийг хийж чадна гэсэн өөртөө итгэх итгэлийг олж авсан нь уг арга хэмжээг зохион явуулсны үр дүнгийн нэг эргэлзээгүй мөн билээ.

Казахстан дахь бөхөнгийн өдөр

Бердияр Жоллибеков, Олон улсын Амьтан, ургамлын аймаг, Berdiyar.Jollibekov@fauna-flora.org

Шалкар тосгоны 5-р сургуулийн “Акбокен” экологийн клуб 5 сард Устюртын бөхөнгийн популяцийг хамгаалах зорилготой өөрсдийн бөхөнгийн өдрийг анх удаа зохион байгуулсан. Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг анх удаа зохион байгуулагдсан энэ бөхөнгийн өдөрт Узбекистаны Каракалпак тосгоны “Табиятиялайк” экологийн клубын залуусыг оролцохыг урьсан нь жинхэнэ утгаар олон улсын шинжтэй үйл ажиллагаа болсон.



Зургийг Айзана Исеева

Узбекистаны эко-клубын гишүүдийн үзүүлбэр

Хүүхдүүд тал хээрийн цорын ганц билэг тэмдэг болсон бөхөнгийн тухай хөгжмийн тоглолт хийсэн. Аялалын хөтөлбөрт “Бөхөнгийн талаар чи юу мэдэх вэ?” сэдэвт хэлэлцүүлэг болсон бөгөөд тэнд хүүхдүүд асар их мэдлэг, оюун ухаан, сонирхлоо харуулсан. Түүнчлэн тэд Устюртад тархан байршиж байгаа ховор ургамал, амьтны талаар сурч мэдсэн. “Бөхөнгийн домог” нэртэй хүүхэддэйн киног үзүүлснээр тэд бөхөнгийн тухайн түүх, учирч буй үндсэн аюул заналын талаар мэдлэгтэй болсон. Хүүхдүүд өөрсдийн хийсэн уламжлалт гар урлалын бүтээл, Шалзар нуураар хийсэн аялал, нарсан ойд зугаалахдаа маш их баяр хөөртэй байсан.

Узбекистаны “Табиятиялайк” эко-клубийн ахлагч Кумисай Золдасова “эко-клубууд нь орон нутгийн бүлэг нөхөрлөл, ялангуяа залуу хүмүүсийг хамгааллын үйл ажиллагаанд татан оролцуулах, туслалаар чухал үүрэг гүйцэтгэж байна” гэж хэлжээ. Тэрээр Каракалпак дахь өөрийн клубийн үйл ажиллагааны талаар гайхалтай танилцуулгыг өгч, залуу үеийн байгаль орчны боловсролд оруулсан өөрийн хувь нэмэр, байгаль дэлхийг хамгаалахад хувь хүний оролцоо, үүрэг хариуцлага, бэлэн байх талаар бэлдсэн үзүүлэнгээ тайлбарласан. “Хүүхдүүд хэрхэн мэдлэг олж байгааг хараад би маш их гайхсан” гэж Каракалпак тосгоны 26 дугаар сургуулийн гүйцэтгэх захирал Салтанат Калиева хэлсэн.

Зургийг Айзана Исеева



Зургийг Айзана Исеева

Казахстаны эко-клубийн гишүүдийн тоглолт

“Энэ бол залуу байх үеэс нь хүмүүсийн сэтгэл зүрхэнд байгаль хамгаалах үзэл санааг суулгаж өгч байгаа маш чухал ажил. Бидний хүүхдүүд бидний ирээдүйг бүтээх болно”

Хоёр орноос ирсэн эко-клубийн гишүүд мартагдашгүй сэтгэгдэлтэй үлдэж, мэдээжийн хэрэг ижил үзэл бодолтой шинэ найз нөхөдтэй болж, Устюртын цорын ганц билэг тэмдэг-бөхөнг хамгаалахад хамтдаа ажиллах хүсэл тэмүүлэлтэй болсон нь хамгийн чухал юм.

Шалкар дахь бөхөнгийн өдрийг Олон улсын амьтан, ургамлын аймгийг хамгаалах холбооноос санхүүжилтээр Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, Казахстаны ХАА-н яамны Он, ангийн нийгэмлэгийнхэн хамтран Диснейн дэлхий дахиныг хамгаалах сан, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн (USAID) Чухал экосистемийн тогтвортой хамгаалах хандлага (SCAPES) хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн бусад чиглэлийн хүрээнд Казахстан, Узбекистаны хил дагуух бүс нутагт хүрээлэн буй орчны мэдээллийн хүртээмжийг сайжруулснаар хил орчмын хамтын ажиллагааг бий болгох, залуу хүмүүсийн оролцоог хангахад чиглэгдэж байна.



Хүүхдүүд Шалкар нуур руу хийсэн аялалын үеэр

Халимагийн бөхөнгийн өдөр

Надежда Арылова, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төв, arylova@gmail.com

Олон улсын бөхөн хамгаалах өдрийн нэг хэсэг болгон Зэрлэг амьтан хамгаалах төвөөс хэрэгжүүлсэн энэхүү үйл ажиллагааны хүрээнд сургуулийн хүүхдүүдэд зориулсан лекц, асуулт хариултын уралдаан, спортын тэмцээн зохион байгуулсан. Энэ баярын зорилго нь хээрийн бүс дэхь бөхөн хамгааллын асуудалд дараа үеийн анхаарлыг хандуулахад чиглэгдсэн. Хамгийн гайхалтай үйл ажиллагааны нэг нь Амур-Санан үндэсний номын санд болсон 10 дугаар сургуулийн 5 дугаар ангийн хүүхдүүдэд зориулсан “Өөрийн төрөлх нутгаа хайрла, мэд” гэсэн экологийн хичээл байсан.



Зургийг Т.Горинаев

Виктория Носытыевагийн лекц



Зургийг Надежда Арылова

10-р сургуулийн сурагчид

Энэ хичээлээр “дөрвөн хөлт нүүдэлчний” хувь заяа, Халимагийн тал нутгийн хүрээлэн буй орчны бусад асуудлыг хөндсөн бөгөөд лекц, видео, “Бөхөн-тал нутгийн туруутан” сэдэвт асуулт хариултын уралдаан хэлбэрээр явагдсан.

Хүүхдүүд “Бөхөнгийн домог” хүүхэлдэйн кино, түүнчлэн Зэрлэг амьтан хамгаалах төвийн Яшкул үржүүлгийн төвийн бөхөнгийн тухай видеог их сонирхон үзсэн. Сурагчид бөхөнгийн биологи, түүний статусын талаар маш сайн мэдээлэл авсан бөгөөд тэд үржүүлгийн төв дэхь бөхөнгийн амьдралыг ихээхэн сонирхож байв. Бүх оролцогчид бөхөнгийн зураг бүхий гэрчилгээг хүлээн авсан.

Артезианаас ирсэн дунд сургуулийн багш Виктория Носытыева Бөхөнгийн өдрийн баярт зориулан Яшкул, Черноземелский дүүргийн таван сургуульд лекц уншсан. Тэрээр тэдэнд, лекц уншиж, видео үзүүлсэн бөгөөд хүүхдүүд Бөхөн хамгаалах нийгэмлэгийн снхүүжилттэй төслийн хүрээнд Викториагийн хийсэн гайхалтай мэдээллийг харсан.

БЯЦХАН БӨХӨНГҮҮД

Бид, бяцхан бөхөнгүүд, хүүхэдтэй адил,
Бид эелдэг гэнэн итгэмтгий зантай.
Үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл
Бид өөрсдийн ээжийнхээ дэргэд аз
жаргалтай цовоо байдаг.

Бид өвс идэж, ус уудаг.
Бид хорон муу санаагүй, итгэмтгий
байдаг.
Гэвч заримдаа бидэнд айдас байдаг
Хүн баавгай бидэнд зовлон учруулна
гэдэгт.

Бид нар бүх хулгайн анчдад хэлэх ёстой:
«Та нар бөхөнг буудах ёсгүй!
Тэд хамгаалагдсан!».

Хэрвээ хулгайн анчид буудсаар байвал,
Тал нутгаас бөхөнгүүд устах болно.

Рената Байделдинова,
Бөхөнгийн нөхөр клубийн гишүүн, Гагун
дунд сургуулийн 4-р ангийн сурагч



Зургийг Тамгана Каримова

Рената бяцхан бөхөнг тэжээж байгаа нь

Биологийн олон янз байдал ба хий, газрын тосны үйлдвэрлэл

Севара Шаропова, Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр-Даян дэлхийн байгаль хамгаалах сан (НҮБХХ-ДДБХС), sevara.sharopova@undp.org

Биологийн төрөл зүйлийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан Ташкентын Хими технологийн дээд сургуулийн Хий-газрын тосны үйлдвэрлэлийн химийн технологи чиглэлээр мэргэшиж байгаа 3 болон 4 дүгээр курсын оюутнууд “Биологийн олон янз байдал ба хий, газрын тосны үйлдвэрлэл” сэдэвт асуулт хариултын тэмцээнийг зохион байгуулсан. Уг дээд сургуульд 500 гаруй оюутан энэ чиглэлээр суралцаж байна. НҮБХХ-ДДБХС-гийн “Узбекистаны хий-газрын тосны үйлдвэрлэлийн бодлого ба үйл ажиллагаан дахь биологийн олон янз байдалдхандах хандлага” төсөл болон Узбекистаны БНУ-ын байгаль хамгаалах төрийн зөвлөлийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан уг асуулт хариултын тэмцээн нь биологийн олон янз байдлыг хамгаалах талаарх мэдлэгийг сурталчлах, ирээдүйд хий, газрын тосны үйлдвэрлэлд ажиллах оюутнуудын дунд хүрээлэн буй орчин ээлтэй бодлыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байсан.

Дээд сургуулийн захирал хатагтай Махпуза Караходжаева уг тэмцээнийг нээн үг хэлсэн. Асуулт хариултын тэмцээн: 1) Узбекистаны ургамал, амьтны аймаг; 2) Биологийн олон янз байдлын үзэл баримтлал; 3) Узбекистаны ландшафтын онцлог; 4) Хий, газрын бүтээгдэхүүний үйлдвэрлэл гэсэн 4 үндсэн сэдвийн хүрээнд явагдсан. “Ногоон тос” баг өдрийн турш өөрсдийн оюун ухаан, асар их мэдлэгтэйгээ харуулсан. Уг тэмцээн эрдэмтэн багш нар болон оюутнуудад туйлын сонирхолтой байсан.



Биологийн олон янз байдал ба хий, газрын тосны үйлдвэрлэл” тэмцээний ялагч нар болон оролцогчид

Жишээлбэл, оюутан Дайер Кабилов анх харахад жижиг зүйл мэт, амьтдын популяцид үзүүлэх нөлөөлөл нь бараг байхгүй мэт санагдаж байсан жишээ нь: хийн хоолой нь бөхөнгийн нүүдлийг хязгаарлагч болдог гэх мэт саад, бэрхшээлийн талаар ямар нэгэн ойлголт байхгүй байсан талаар ярьж байв. Өөр нэгэн оюутан Шохрух Холматов уг үйл ажиллагаанаас биологийн олон янз байдлын хамгаалалд хүн бүрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагатай байх ёстойг мэдсэн гэж тэмдэглэжээ. Уг нутагт биологийн олон янз байдлын хамгаалалд туршилт судалгааны мэдлэгийн хэрэглээг нэмэгдүүлэх хэрэгтэйг энэ үйл ажиллагаанд оролцсон оюутнууд сонирхолтой байгааг харуулсан. Иймээс бид биологийн олон янз байдлын хамгааллын талаарх мэдээллийг сурталчлахад туслах илүү олон үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж байгаа ба өөр өөр их дээд сургуулиудын оюутнуудыг оролцуулан биологийн төрөл зүйлийн талаарх энэхүү тэмцээнийг жил бүр зохион байгуулах ёстой гэсэн санал гаргасан.

Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн Өмнөд Хятадын төслөөс анхаарлаа хандуулж буй бөхөн

Фенглиан Ли, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөр (WCS-China), fli@wcs.org

Зэрлэг амьтдын хууль бус наймааг багасгахад туслахаар Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газар 2008 оны 8 сард Гуанжоуд Өмнөд Хятадын төслийг эхлүүлсэн. Уг төслийн үндсэн зорилго нь Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенцийн I, II хавсралт, тэг квот болон улсын I дүгээр зэрэглэлээр хамгаалагдсан амьтад, Гуандоны орон нутгийн хуулиар хориглосон бусад зүйл амьтдын хууль бус наймааг зогсооход оршино. Энэ зорилгын хүрээнд хэрэгжүүлж буй бидний хамгийн чухал зорилгын нэг бол зэрлэг амьтадтай холбоотой гэмт хэргийг багасгахад чиглэгдсэн орон нутгийн хууль сахиулах байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх юм. Бөхөн (*Saiga tatarica*) бол Өмнөд Хятадын төслийн анхаарлаа хандуулж буй зүйл юм. Өмнөд Хятадын төсөл нь 2009 оноос эхлэн боловсролын хөтөлбөр, оюуны чадамж дээр суурилан засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагуудаас хуулийн хэрэгжилтийг зохицуулах, зах зээлийн судалгаа зэрэг Гуанжоу дахь бөхөнгийн түүхий эдийн хууль бус наймааг багасгахад чиглэсэн 3 жижиг тэтгэлгийг Бөхөн хамгаалах сангаас авсан.



ЗАХН-ийн Хятад дахь хөтөлбөрийн Өмнөд Хятадын төслийн баг болон сайн дурын ажилчид

Шувуу судлаачид бас бөхөнд дуртай

Соня Розенфелд, ОХУ, ШУА-ийн А.Н.Северцовын нэрэмжит Экологи Эволюцийн хүрээлэн rozenfeldbro@mail.ru

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Зүйлийн мэнд үлдэлтийн зөвлөлийн Галуу судлаачдын багийн 13 дахь уулзалт Евроазийн хойд хэсэг дэхь оросын галуу, хун, нугас судлаачдын багийн (GSDSG) 4 дэхь уулзалттай давхцан 2011 оны 3 сарын 24-29-нд Халимагийн БНУ-ын Элиста хотод зохион байгуулагдсан. “Хойд евроазийн усны шувууд, газарзүйн тархац, популяци болон хүрээлэн буй орчны хөдлөл зүй, популяцийн динамик” сэдэвт уг хуралд 18 орны 140 гаруй оролцогчид цугларсан.

(<http://onlinereg.ru/Elista2011>, <http://onlinereg.ru/site.php?go=153&page=2819&lang=RUS>).

Зохион байгуулагчид хагас гаршуулсан нөхцөлд бөхөнд харж чадах дэлхий дээрх 3 газрын нэг болох Халимагийн цорын



Зургийг Юрий Арылов

Жералд Малле, Ремо Пробст болон Соня Розенфелд нар үржүүлгийн төвд

ганц газар-Зэрлэг амьтдыг хамгаалах төвд айлчлахаар оролцогчидоо урьсан. Хурлын дараа арван дөрвөн оролцогч Халимагийн өргөн уудам тал, хөрш зэргэлдээ Астрахан муж, түүнчлэн агуу Волго Делтаг харах аялалд мордсон. Степной дархан газарт зэрлэг бөхөнгийн мөр, түүнчлэн 2 бодгалийг харсан бөгөөд энэхүү өргөн уудам нутагт хулгайн анг зогсоохоор тэмцэж буй хулгайн антай тэмцэх багийг хэрхэн маш сайн тоноглогсныг бид үзсэн.

Австрийн “Шувуудын амьдрал” байгууллагын бүс нутгийн салбар Каринтиагийн “Шувуудын амьдрал” ТББ Австрийн өмнөд хэсгийн орон нутгийн шувуудыг хамгаалах чиглэлээр ажилладаг. Гэсэн ч тэд дэлхий дээрх зөвхөн шувууд төдийгүй ангилал зүйн өөр нэгжид хамаарах амьтдыг сонирхож байв. Уг байгууллагын захирал Ремо Пробст болон гүйцэтгэх захирал Жералд Малле нар 2012 оны 5 сарын 17-нд бөхөн үржүүлгийн төвд айлчилсан. Аялалын дараа Ремо Пробст хэлэхдээ: “Бид Степной дархан газрын бөхөн үржүүлгийн төвд айлчлах урилга хүлээн авсандаа, мөн хамгааллын хамгийн сайн жишээнээс суралцах болсонпоо туйлын байртай байсан. Бөхөн, шувуу зэрэг тухайн нутгийн зүйлүүд, мэдээжийн хэрэг үзэсгэлэнт тал нутгийг харах маш сонирхолтой байсан. Хэдийгээр бид шувуу судлаач нар ч гэлээ газрын тогтоц, түүнчлэн амьдрах орчныг маш их сонирхож байв. Бид маш ноцтойгоор буурч буй бөхөнд аврахаар хүмүүс хэрхэн эрч хүчтэй ажиллаж байгааг харсан. Түүгээр ч үл барам, бөхөнд хамгаалах нь зөвхөн тухайн зүйлийг хамгаалах асуудал биш төдийгүй олон тооны шувууд, ангилалзүйн бусад хүрээний амьтдын амьдарч буй тал хээрийн экосистемийг хамгаалахад чухал ач холбогдолтой болохыг бид ойлгосон. Иймээс тал хээрийн экосистемийг хамгаалахад тэдний үүрэг оролцоо чухал ач холбогдолтой учраас уг төслийг үргэлжлүүлэх, мөн өргөжүүлэх шаарлагатайг зөвлөж байна!” гэжээ.

Алтан ахууна бөхөнд аюулаас ангижруулах болно

Александр Клепалов, ГАЛА-Кино студи, alexman78@list.ru

Сибирийн зуны улирал эхлэх үеэр өмнөх уламжлалын дагуу хүрээлэн буй орчны телевизийн сэтгүүлчдийн цуваа Ханги-Мансиск рүү хөвөрдөг. Олон улсын хүрээлэн буй орчны телевизийн “Хадгал, хамгаал” кино наадам 16 дахь удаагаа зохион байгуулагдаж, хол ойрын 30 гаруй орны төлөөлөл, түүнчлэн ОХУ-ын 60 гаруй хотоос зочид, гийчид уригдсан. Тэд бол олонд танигдсан телевиз, кино студийн захирал, сэтгүүлч, экологич нар байсан. Шүүгчдийн бүрэлдэхүүнд танилцуулсан 300 орчим бүтээлээс хамгийн сайн 70 бүтээлийг сонгон нийтэд хүргэхээр болсон. Эдгээр нь экологийн баримтаг, нийгмийн мэдээлэл, хүрээлэн буй орчныг хамгаалах сэдэвт бүтээлүүд бөгөөд хамгийн том шагнал болох “Алтан ахууна”-ийн төлөө өрсөлдсөн.

Уг наадам байгаль хамгаалалд шинэ түлхэц өгсөн. Оролцогчид байгаль руу чиглэсэн хандлагын хариуцлага, болгоомжтой харьцах талаар өгүүлсэн түүхийг танилцуулсан. Наадмын уур амьсгал сонирхолтой хүмүүстэй уулзах, кино үзэх, хөтөлбөрүүд болон мастер анги, харилцан яриа зэргээр дахин давтагдашгүйгээр өрнөж байсан.



Зургийг Бөхөн хамгаалах нийгэмлэг

Амьтан халамжлах Олон улсын сангийн Орос дахь хөтөлбөрийн (IFAW-Russia) захирал, шүүгчдийн зөвлөлийн гишүүн Мария Воронцова киноны зураглаач Александр Клепаловт шагналыг ёслол төгөлдөр гардуулж байгаа нь

Оролцогчид энэхүү хатуу ширүүн уур амьсгалтай газар нутгийн байгалийн гайхамшигт байдал нь цаашид урлагийн бүтээл хийх хүсэл тэмүүлэлийг тэндэнд өгсөн гэж хэлж байв.

Энэ жилийн наадмын хувьд “Сэлгүүлчийн ажиглалт” номинацийн “Алтан ахууна” хэмээх нэр хүндтэй шагналыг Бөхөн хамгаалах нийгэмлэгийн захиалга, Дисней Канада, Марш Христийн сан, ДВВ Интернэйшнлийн санхүүжилтээр Ташкентийн ГАЛА кино студийн бүтээсэн “Шугамын төгсгөлд” нэртэй бөхөнгийн тухай бүтээл авсан (Бөхөнгийн мэдээ 14-оос хар).

“Шугамын төгсгөлд” нэртэй уг кино энэ гамшиг хэрхэн болж байгааг, энэ эмгэнэлт хэрхэн тохиолдож байгаа, үүний дээд хязгаарт хүрсэн Узбекистаны бөхөнгүүд хэрхэн амьдарч байгааг харуулснаараа шүүгчдийн багийнхны анхаарлыг ихээр татсан. Хэрвээ хүмүүс хөндлөнгөөс оролцохгүй бол манай улсын тал хээрийн туруутны зүйл болох бөхөн ойрын ирээдүйд устан алга болох болно.

Экологийн сэтгүүлчид ахууныг аз жаргалын шувуу гэж дууддаг бөгөөд бид Алтан ахууны жигүүр нь тулгарч буй аюулаас бөхөн хоргодох бэхлэлт болно гэдэгт итгэлтэй байна.



Зургийг Бөхөн хамгаалах нийгэмлэг

Александр Клепалов наадмын шагнал “Алтан ахууна”-тай хамт

Хууль бусаар бөхөнгийн эвэр худалдаалахын эсрэг мэдээллийн кампанит ажил эхэллээ.

Занна Аксартова, Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, zhanna.aksartova@acbk.kz

Энэ жилийн 6 дугаар сараас Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг Казахстаны хотуудад хүчээ авч байгаа бөхөнгийн эврийн худалдаалалтыг эсэргүүцэн мэдээллийн кампанит ажил эхлүүлсэн.

Казахстаны БНУ-ын эрүүгийн хуулийн 290 дүгээр хэсэгт “Ховордсон ургамал болон амьтан/тэдгээрийн эд эрхтэн, дайвар бүтээгдэхүүнийг хууль бусаар худалдах, худалдан авах, хадгалах, борлуулах, импортлох, экспортлох, илгээх, зөөвөрлөх, устгах, мөн хуулиар хориглогдсон ургамал, амьтан, түүний эд эрхтэн, дайвар бүтээгдэхүүн болон тэдгээрийн амьдрах орчныг ашиглавал 3 жилээс дээш хугацаагаар шоронд хорих буюу түүнтэй ижил хугацаагаар зөрчил гаргагчийн эд хөрөнгийг битүүмжлэх буюу улсын орлого болгоно” гэсэн зүйл ангийг энэ жилийн 2 сард баталж, мөрдөж эхлэсэн. Энэ бүхнийг үл харгалзан Казахстаны хотуудад нүд хуурсан үнээр бөхөнгийн эврийг захиалан авах үйл ажиллагаа тогтмол өссөөр байна.

Кампанит ажлын зорилго нь өргөн хүрээнд хийгдэж буй бөхөнгийн эврийг худалдахыг саармагжуулах, худалдаалах үйл ажиллагааг саармагжуулах, эдгээр үйлдэлд орон нутгийн хүмүүсийн хэрхэн хариу үйлдэл үзүүлж буйг мэдсэнээр хууль бус агнуурыг хязгаарлах болно. Бөхөнгийн эврийн худалдаа нь өөрсдөд нь болон байгальд хэрхэн аюул учруулж буйд олон нийтийн анхаарлыг хандуулахыг Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг хүсэж байгаа бөгөөд үүний тулд олон нийтийн үзэл бодлыг өөрчлөх, зэрлэг амьтан хамгаалах хуулийн зөрчлийг багасгах, аливаа зөрчлийн хатуу чанга шийтгэлийн талаар дуулаагүй байгаа хүмүүст мэдүүлэхэд оршоно.

Энэ байр суурийг дэмжиж байгаа бүх хүмүүсийг дараах зүйлд уриалж байна:

- Хэрвээ та олон нийтийн газар (автобусны зогсоол, гэрэлтүүлэг, их дэлгүүр) явахдаа бөхөнгийн эвэр худалдсан болон худалдан авсан ямар нэгэн ул мөр олвол дор харуулсан шийдвэр, тэдгээрийг худалдаалах нь хууль бус үйлдэл болох тухай утга агуулсан Эрүүгийн хуулийн №290 дүгээр

зүйлийн хэсэг бүхий шошгыг наана уу. Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгийн веб хуудас болох www.acbk.kz-аас уг шошгыг хаанаас, хэрхэн олж авах тухай мэдээллийг олж болно.

- Уг хэрэгт хамааралтай угасны дугаарууд руу SMS мессежийг илгээснээр худалдагч/худалдан авагч нарын хууль зөрчих үйл ажиллагаанд сэрэмжлүүлэг өгөх болно. Та бүхэн acbk@acbk.kz-руу е-мэйл илгээснээр болон олон нийтийн сүлжээний хуудас <https://www.facebook.com/groups/443937775636114/and> <http://vk.com/event39122337> -нд хандсанаар уг анхааруулсан мессежийг авах боломжтой.

КБТЗХН таны дэмжлэгт найдаж байна!

УГОЛОВНОЕ ДЕЛО!

Охота на сайгаков, а также торговля СТАРЫМИ и НОВЫМИ рогами в Казахстане запрещена. Нарушение данного запрета наказывается ограничением свободы на срок до 3 лет или лишением свободы с конфискацией имущества.

Уголовный кодекс РК Статья 290

Хэвлэлийн мэдээ:

Казахстан-Узбекистаны хил дагуу тор татах ажлын талаарх сүүлийн үеийн мэдээ

Казахстан улс 2011 оны намраас эхлэн баруун зүгт Узбекистантай хил залгаа хэсгээс зүүн зүг рүү чиглэсэн 100 орчим км урттай торыг барьсан. Хилийн зүүн хойд өнцгөөс өмнө зүг рүү чиглэсэн 50 км урттай өөр нэгэн торон хашааг барьсан. Газрын гадаргаас 180 см өндөртэй энэ өргөст утсан хаалт нь зөвхөн бөхөнд төдийгүй жижиг амьтдад ч гэсэн хил дамнан нүүдэллэхэд саад учруулж байна.

Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж харна уу.

http://www.uznews.net/news_single.php?lng=ru&sub=hot&cid=4&nid=19639.



Зургийг Узбекистаны мэдээ

Казахстан Узбекистаны хил орчим, Устиюртын тал дахь өргөст торон хашаа

Бөхөнгийн эврийг худалдаалах явдлын эсрэг Кызылордагийн цагдаагийн хэлтсээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанууд

Кызылордагийн цагдаагийн хэлтэс өөрсдийн хариуцсан бүс нутагт бөхөнгийн эврийн худалдааг таслан зогсоох зорилгоор хяналт шалтгалтын ажлыг эрчимтэй гүйцэтгэж байна. Худалдаачид боломжит бүх арга, хэрэгслийг ашиглан бөхөн эвэр худалдан авах сонирхолтой байгаагаа түгээж байна. Цагдаагийнхан худалдаачдыг утасны дугаараар нь мөрдөх, эрэн сурвалжлах үйл ажиллагааг зохион байгуулж, эсвэл эд мөрийн баримттай нь баривчилж чадна. Харин эдгээр эврүүдийг тээвэрлэж буй “тээвэрлэгч”-ийг шүүхийн өмнө авчрах нь хэцүү юм. Хүрээлэн буй орчны цагдаагийн хэлтэс бөхөнгийн эврийн худалдааны замыг доорхи байдлаар томъёолсон: Казахстанд хулгайгаар агнагдсан бодгалийн эврийг Хятад руу хууль бусаар зөөвөрлөн оруулдаг. Тэд Орос-Хятадын хилийн бүс болох Приморийн хязгаар эсвэл Алс Дорнодын алс нэг рүү тээвэрлэдэг бөгөөд тэнд нэг кг эврийн үнэ 20000 рублиэс (630 ам доллар) дээш үнэд хүрдэг байна. Кызылордад байгалийн жамаар үхсэн бөхөнгийн “хуучин” эвэр 2-3 мянган тэнгэ (15-20 ам доллар) байдаг боловч шинэ, хууль бусаар агнасан бөхөнгийн эвэр илүү их үнэд хүрдэг.

Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж харна уу

<http://www.zakon.kz/kazakhstan/4476050-policejjskie-kyzylordy-objavili-voijnu.html>.

Ус уух газрыг бий болгох нь Казахстаны бөхөнгийн тоо толгой өсөхөд тустай

Казахстаны нутагт Казахмыс компанийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Коргалзын байгалийн нөөц газрын баруун хэсэгт ундны усыг сэргээн байгуулах” төсөл 2010 оноос хэрэгжиж эхлэсэн. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Тернсай, Тобылгысай, Акбокен даланг сэргээсэн. Төсөлд оролцогчдын бодлоор уг байгалийн нөөц газарт бөхөн холоос нүүдэллэн ирдэг ба тэд ундны ус хайн ямар нэгэн хамгаалалтын статусгүй нутаг руу орох нь хулгайн анчдын гарт өртөх боломжийг нэмэгдүүлдэг гэж үзжээ. Ашиглагддаггүй, эвдэрсэн даланг сэргээн босгосноор ус уух газрыг бий болгох нь бөхөнгийн шилжилт хөдөлгөөнийг нилээд хэмжээгээр багасгана. Эдгээр арга хэмжээ нь Тэнгыз нуурын ойролцоох усны шувуудын тоог өсгөх ач холбогдолтой. Найман далан нөхөн сэргээгдэхээр төлөвлөгдөж байна.

Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж харна уу.

http://locman.kz/newsonly.php?ID=29524#.T_3Cl5Ey2M8.

Бөхөн хамгаалах цахилгаан хашаа

Яшкул үржүүлгийн төвд бөхөнг махчдаас хамгаалахын тулд цахилгаан хашаа барьж байгуулах ажил дуусжээ. Цахилгаан ороомог нь хашааны бүх тойргийн дагуу 4 мөрөөр байрласан. Халимагийн Улсын их сургуулийн Хөдөө аж ахуйн тэнхмийн оюутнууд уг төвийн ажилчдад хашаа барихад тусалсан. Уг хашаа нь нарны зайгаар цэнэглэгдэнэ. Хэрвээ мах идэшт амьтад хашаанд ойртвол сул хүчдэлтэй цахилгаан гүйдэлд цохиулан хашаанаас зугтаана. Энэ нь мах идэшт амьтад ямар нэгэн сөрөг нөлөөгүй бөгөөд махчдыг хашаанаас зугталгах ач холбогдолтой.

Энэхүү ажил нь ДБХС-гийн Орос дахь хөтөлбөрийн газар, НҮБ/ДДБХС/Оросын байгаль орчны яам болон Елистагийн бизнесмен эмэгтэй Олга Обгенова нарын дэмжлэгтэйгээр хийгдсэн. *Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосоор орж харна уу:*

<http://www.unmultimedia.org/radio/russian/archives/117703/>



Зургийг Наокева Арьюлова

Бөхөнгийн хашааны бүх тойргийн дагуу суулгасан цахилгаан хашаа

Амьтны эрүүл мэндийн олон улсын сан (IFAW) бөхөн хамгаалахад Орост туслах болно.

Амьтны эрүүл мэндийн олон улсын сан нь 2012 онд Оросын өмнөд хэсгийн бөхөн хамгаалахад нэг сая рублийн (\$31,300) хандив өгөх болно. Энэ мөнгө нь Астраханы бүс нутаг дахь Степной БНГ-ын үйл ажиллагаанд болон Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төвд буй амьтдыг тэжээх зорилгоор зарцуулагдах болно.

Өнөө үед бөхөн нь ОХУ-ын Халимагийн БНУ-ын Астраханы бүс нутгийн хэрт тохиолдож байна. Сүүлийн үеийн судалгааны үр дүнгээс үзвэл ОХУ-ын тус нутагт 12000-аас цөөн тооны бөхөн байгаа гэж үзсэн бол Амьтны эрүүл мэндийн олон улсын сангийн шинжээчид 7000-аас илүү бодгаль байхгүй гэж үнэлсэн байна.

Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж харна уу.

http://www.elista.org/index.php?option=com_content&view=article&id=14400:2012-06-15-05-46-47&catid=1,
<http://eco.ria.ru/nature/20120615/673645518.html>.

Яшкулдын зэрлэг амьтдын үржүүлгийн төв болон Степной БНГ-т айлчилсан Амьтны эрүүл мэндийн олон улсын сангийн (АЭМОУС) төлөөлөгч Елена Зарковагийн сэтгэгдэл АЭМОУС-гийн вэбсайтаас авах боломжтой.

<http://www.ifaw.org/united-states/news/watch-true-happiness-steppe-meeting-saiga-antelope>.

Степной БНГ-т саяхан айлчилсан блогчин, гэрэл зурагчин Евгений Полонскийгийн гэрэл зургийн цомгийг доорхи холбоосоор орж харна уу:

<http://e-polonskiy.livejournal.com/63311.html>

Бөхөн агнасан болон хууль бус худалдааны хэргүүд

Казахстан

2012 оны 1 сарын 6

Бетнак-далагийн популяци: Иргыз дүүргийн Зайсанбай тосгоноос 80 км зайд Иргыз дүүргийн цагдаагийн ажилтнууд Кызыл-Орда мужийн харьяалалтай иргэний жолоодож явсан Тоёота Ланд Круйзер машиныг саатуулсан; машины дотор талд 2 амтай ангийн буу явсан бөгөөд машинд нэгжлэг хийсэн цагдаагийн ажилтан эвэргүй 5 бөхөнгийн гулууз мах олсон.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосоор орж харна уу.

<http://www.avestnik.kz/?p=16078>.

2012 оны 1 сарын 28

Бетнак-далагийн популяци: Актобе дэхь эрэн сурвалжлах ажиллагааны явцад цагдаагийн ажилтны саатуулсан 26 настай иргэний машинаас 12 бөхөнгийн эвэр олдсон. Тэрээр хот болон ойролцоох нутгийн шуудангийн салбараар дамжуулан нэг кг-ийг нь 60,000 тэнгэгээр (\$400) үнэлэн зарах зорилгоор бөхөнгийн нэг хос эвэргүй 12,000 тэнгэгээр (\$80) үнэлэн худалдан авсан болохоо хүлээсэн. Тэрээр өнгөрсөн 2 сар гаруйн хугацаанд 102 бөхөнгийн эвэр цуглуулсан бөгөөд гэртээ хадгалж байсан байна. Эрүүгийн хуулийн 190, 183-р зүйл ангиар шийтгэгдсэн уг хэргийг одоогоор хянаж байна.

Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж хана уу

<http://inform.kz/rus/article/2438108>.

2012 оны 2 сарын 6

Олон улсын шинжтэй хэрэг: Атырау мужийн (Орос, Казахстаны хооронд) Курмагазу хилийн шалган нэвтрүүлэх цэгт их хэмжээний бөхөнгийн эвэр саатуулагдсан. Алматыгийн хоёр иргэн 170 бөхөнгийн эвэрийг Казахстан руу нэвтрүүлэхийг оролдсон. Контробандын наймаа хийгчид уг эвэрийг ОХУ-ын Астраханаас худалдан авсан бөгөөд Шумкентэд борлуулах төлөвлөгөөтэй байснаа хүлээсэн. Хэргийг шалгаж байна.

Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж харна уу.

<http://inform.kz/rus/article/2438956>,

<http://www.zakon.kz/kazakhstan/4472483-v-atyrau-nezakonno-pytalis-sbyt-8.html>.

2012 оны 3 сарын 10

Бетнак-далагийн популяци: Охотзоопромын байцаагч нар болон Залагаз дүүргийн цагдаагийн ажилтнууд Кызыл-Ордагийн 4 иргэн сууж явсан бартаат замын машиныг саатуулсан. Цагдаагийн ажилтан уг машины ачааны хэсгээс ангийн буунууд, сум, цусны толбо, амьтны үс зэргийг олсон. Машины явсан мөрийг мөрдөж үзэхэд 3 бөхөнгийн гулуузыг олсон. Хууль бус ан хийсний төлөө эрүүгийн хэрэг үүсгэсэн. *Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж харна уу.*

<http://tengrinews.kz/crime/209828/>.

2012 оны 3 сарын 19

Олон улсын шинжтэй хэрэг: Капшагайн шалган нэвтрүүлэх цэгийн ойролцоо Алматы дүүргийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй гэмцэх хэлтэс болон замын цагдаагийн ажилтнууд их хэмжээний бөхөнгийн эвэр, заарт минжийн арьс болон “баймур”-ын үндэс (*Fritillaria pallidiflora* Schrenk) зэргийг хил давуулахаар оролдсон Өмнөд Казахстаны районы Сары Терек тосгоны оршин суугчийг саатуулсан. Цагдаагийнхан 4704 бөхөнгийн эвэр, 10608 минжийн арьс, 3 шуудай “баймур”-ын үндсийг хураан авсан. Цагдаагийн ажилтнууд худалдаачид болон нийлүүлэгчийг танин мэдэхээр хяналт шалгалтын ажлыг хийж байна. Саатуулагдсан эдгээд эдгээр зүйлийг Хятад руу гарч арилжахын тулд Зайсан (Зүүн Казахстан) руу хүргэхээр авч явжээ.

2012 оны 3 сарын 20

Олон улсын шинжтэй хэрэг: Тогтмол хугацаанд явагддаг шалтгалтын үеэр Курмангазы хилийн шалган нэвтрүүлэх цэг дээр (Орос, Казахстаны хил) Алматыгийн оршин суугчийн хил нэвтрүүлэхээр авч явсан 178 ширхэг бөхөнгийн эвэрийг хураан авсан. Эдгээр нотлох баримтыг Курмангазы дүүргийн цагдаагийн хэлтэст шилжүүлсэн. Анхан шатны хэрэг бүртгэлийн ажиллагаа эхлэсэн. *Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж авна уу.*

<http://www.zakon.kz/kazakhstan/4481427-krupnejshaja-partija-rogov-sajgi-i.html>.

2012 оны 5 сарын 27

Бетнак-далагийн популяци: Иргыз тосгоноос 45 км зайд Актыуба дүүргийн Куланши бүсэд орон нутгийн иргэний жолоодож явсан бартаат замын машиныг саатуулсан бөгөөд машин дотроос бөхөнгийн гулууз болон 2 бөхөнгийн эвэр олдсон. Эрүүгийн хуулийн 288 дугаар зүйл ангиар буюу “Хууль бус агнуур” үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэсэн.

Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж харна уу.

<http://inform.kz/rus/article/2467509>.

2012 оны 6 сарын 5

Бетпак-далагийн популяци: Актыуба бүсийн Актебия дүүрэгт Охотзоопромдын байцаагч нар Кырыкудык тосгоноос 12 км зайд эврийг хөрөөдөн авсан 60 бөхөнгийн гулуузыг олсон. Мөн бартаат замын машины мөр, бууны хонгио зэргийг олсон. Сүүлд Дотоод явдлын хэлтсийн цагдаагийн ажилтнууд болон Арлан тусгай бүлэг Кызыл-орда мужийн нутагт сэжигтэй хүнийг саатуулсан. Бөхөнгийн эврийг олох хяналт шалгалтын ажил үргэлжилж байгаа бөгөөд эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосоор орж авна уу

<http://rus.azattyk.org/content/saiga-otstrel-roga-aktobe/24614906.html> болон
<http://today.kz/ru/news/incident/2012-06-15/67726>.

2012 оны 6 сарын 15

Бетпак-далагийн популяци: Охотзоопромдын ажилтнууд болон хүрээлэн буй орчны цагдаа нарын хамтарсан шалгалтаар Улытау дүүргийн Караганда тосгонд Терсаккан тосгоны оршин суугчийн жолоодож явсан УАЗ машиныг саатуулсан бөгөөд машин дотроос бөхөнгийн гулуузыг олсон. Эрүүгийн хуулийн 288 дугаар зүйл ангиар (Хууль бус агнуур) эрүү үүсгэн шалгаж байна.

Дэлгэрэнгүйг доорхи холбоосоор орж харна уу

<http://www.zakon.kz/kazakhstan/4497187-dvukh-brakonerov-s-tushejj-sajjgaka.html>.

2012 оны 6 сарын 18

Уралын популяци: Баруун Казахстаны Ақоба тосгонд хийсэн хяналт шалгалтын явцад Ой, ангийн нийгэмлэг болон Охотзоопромдын ажилтнууд 12 хос бөхөнгийн эвэр болон ангийн буу олсон. Хууль бус ан үйлдсэн хэргээр эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд мөрдлөгийн ажиллагаа явагдаж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосоор орж авна уу

http://www.kazakh-zerno.kz/index.php?option=com_content&view=article&id=59443:-12-&catid=14&Itemid=108.

2012 оны 7 сарын 7

Бетпак-далагийн популяци: Хүрээлэн буй орчны цагдаагийн ажилтнуудын хяналт шалгалтын явцад Ақтоба тосгоны иргэнийг тээвэрлэн Иргиз тосгоны оршин суугч жолоодож явсан машиныг саатуулсан бөгөөд бөхөнгийн гулуузыг, 5 хос бөхөнгийн эвэр, ангийн бууг хураан авсан.

2012 оны 7 сарын 9

Бетпак-далагийн популяци: Дотоод явдлын хэлтсийн ажилтнууд Актыуба тосгоноос Карабутак тосгоны 2 иргэн, Ақтоба тосгоны оршин суугчийг саатуулсан бөгөөд тэдний машинаас 5 бөхөнгийн гулуузыг, 2 ангийн буу олсон. Баригдсан хүмүүс бөхөнгийн хууль бус агнуурын хэрэгт буруутгагдсан. Эрүүгийн хуулийн 288 дугаар зүйл ангиар (Хууль бус агнуур) эрүү үүсгэн шалгаж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосоор орж авна уу

<http://kt.kz/?lang=rus&uin=1133168098&chapter=1153557197>.



Зургийг Евгений Полоцкий, Оросын Астрахань бүсэд

Орос болон Казахстанд ердийн үзэгдэл болсон “Бөхөнгийн хуучин эвэр худалдаж авна” гэсэн утгатай зарлал

Узбекистан

2012 оны 2 сарын 23

Устюртын популяци: Аму Даряагийн мэргэжлийн хяналтын газар болон Каракалпакстаны гаалийн байгууллагын ажилтнууд Кунград дүүргийн Каракалпакия төмөр замын өртөөн дээр 302 бөхөнгийн эвэр хил нэвтрүүлэхээр завдсан Узбекистаны оршин суугчийг саатуулсан. Мөрдлөгийн ажиллагаа үргэлжилж байна.

Хятад

2012 оны 3 сарын 30

Алтайн гаалийхан ховордсон зэрлэг амьтны түүхий эдийг хууль бусаар хил давуулан орж ирсэн нэг тохиолдлыг илрүүлсэнийг Өрөмчийн гаалийн газар зарласан бөгөөд улсын хилээр орж машинаас бөхөнгийн эвэр олдсон байна. Жимунай шалган нэвтрүүлэх цэг дээр хийгдсэн хяналт шалгалтын үеэр 163 кг жинтэй 876 бөхөнгийн эврийг суудлын вагоны тасалгаанд шатахууны сав байдлаар далдан хийсэн байсныг олсон. Уг хэрэг Хил дамнасан хууль бус наймааны эсрэг хэлтэст шилжсэн.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи холбоосоор орж харна уу.

<http://www.chinanews.com/fz/2012/04-01/3793429.shtml>.



Зургийг Хятадын мэдээ.com

Хятадад хураагдсан бөхөнгийн эвэр

Монгол орны бөхөнгийн янзаганы мэнд үлдэлтийн болон орон зайн экологи

Баярбаатар Бүүвэйбаатар^{1,2*}, Тодд К.Фуллер¹, Аманда Е. Файн²

¹АНУ, Массачусетсийн их сургууль, Хүрээлэн буй орчны хамгааллын тэнхим;

²Монгол улс, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь хөтөлбөр

Харилцах автор: Баярбаатар Бүүвэйбаатар, buuveibaatar@gmail.com

Монгол бөхөн (*Saiga mongolica*; энэ дугаарын гол мэдээний өгүүллээс хар) баруун Монголын цөлөрхөг хээрийн экосистемд тохиолдох 5000-7000 бодгаль бүхий популяци юм. Монгол бөхөнгийн 3 дэд популяци байдаг бөгөөд одоогоор тэдгээр нь өмнө нь тархаж байсан нутгийн дөнгөж 20%-д нь тохиолдож байна. Сүүлийн жилүүдэд Монгол орны бөхөнгийн популяцийн хэмжээ болон тархац нутаг өсөж байгаа нь хуулийн хэрэгжилт сайжирч буйтай холбоотой юм. Зэрлэг амьтад болон тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад тусгай хамгаалалттай газар нутаг нь хамгийн нийтлэг, үр дүнтэй арга юм. Өнөөгийн байдлаар Монгол орны бөхөнгийн 30-аас доош хувь нь хамгаалагдсан бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн тоо болон хэмжээг нэмвэл бөхөнгийн амьдрах орчныг үр дүнтэй хамгаалж чадна. Шарга БНГ-ын хил доторхи бөхөнгийн шижилт хөдөлгөөн, мэнд үлдэлтийн талаар ихээхэн мэдлэг хуримтлагдсан хэдий ч уг нөөц газрын хилийн гаднах хэсэгт байх бөхөнгийн экологийн талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй байна. Тусгай хамгаалалттай газар нутаг нь бөхөнгийн янзаганы мэнд үлдэлтэнд эерэг нөлөөтэй болохыг тодорхойлохын тулд бид Шарга БНГ болон Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдаагүй, өмнөх бөхөн төллөдөг газраас зүүн хойш 40 км зайд орших Хүйсийн говийг хамруулан 3088 км² нутагт бөхөнгийн янзага барьж хүзүүвчилсэн. 2012 оны 6 сарын 11-нээс 21 хүртэлх


хугацаанд бид Хүйсийн говьд 10 эр, 10 эм, Шаргын говьд 8 эр, 12 эм янзага, нийт 24 сөнгө, 16 ихэр янзага барьж хүзүүвчилсэн. (Зураг 1). Янзаганы биеийн жин дунджаар 2.43 ± 0.39 кг ($n=40$) байсан бөгөөд Шарга болон Хүйсийн говиос барьсан янзаганы биеийн жингийн хооронд ялгаа байгаагүй ($t=0.03$, $p=0.48$). Шар үнэг (*Vulpes vulpes*) нь Шаргын говьд түгээмэл тохиолдсон бол Хүйсийн говьд гол төлөв хярс (*Vulpes corsac*) ажиглагдаж байв. Хүзүүвч зүүх хугацаанд Шаргын говьд хүзүүвчилсэн 3 янзага үнэг болон махчин шувуудын нөлөөгөөр хорогдсон. Хүйсийн говьд хоёр янзага тодорхойгүй мах идэшт амьтан болон өвчний улмаас хорогдсон. Одоогийн байдлаар хүзүүвчилсэн амьтдын мониторинг судалгаа нь хоёр нутгийн янзаганы шилжилт, хөдөлгөөний баримт мэдээлэл цуглуулах түвшинд явагдаж байна.

Энэ хандлага нь тусгай хамгаалалттай нутгийн хилийн гадна болон доторхи янзаганы мэнд үлдэлт, амьдрах орчны ашиглалт, зан төрх, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой экологийн болон менежментийн нарийвчилсан асуудлыг шалгах боломж олгох болно. Энэ судалгааг Үндэсний Газарзүйн нийгэмлэг (National Geographic Society) санхүүжүүлсэн.



Зургийг Баярбаатар Бүүвэйбаатар

Баруун монголын Шаргын БНГ-т радио дохиолол бүхий хүзүүвч зүүсэн янзага



Зураг 1. Баруун Монгол дахь судалгааны талбайн зураг

Пре-Каспийн бүс нутгийн бөхөнгийн амьдрах орчны ашиглалтыг үнэлэхэд хамтын оролцооны мониторингийн аргыг ашиглах нь


Грэхэм Еллиот¹, Юрий Арылов², Анатолий Клюднев³, Е.Ж. Милнер-Гулланд¹

1- Лондонгийн Эзэн хааны коллеж, 2- Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан хамгаалах төв,
3- Степнойн нөөц газар, Астраханы бүс

Харилцах автор: Грэхэм Еллиот, graham.elliott10@imperial.ac.uk

Пре-Каспийн бүс нутгийн бөхөнгийн өнөөгийн тархац нутгийг тодорхойлоход хамтын оролцооны мониторинг хөтөлбөрийн цуглуулсан мэдээлэл тусалж байна. Руффордын сан, Мухамед Бин Зайдын сангаас санхүүжиж буй уг төсөл өвөл, хаврын улиралд бөхөнгийн тархцыг тодорхойлох, энэ тархалтыг чухам юу жолоодож байгааг тодорхойлоход чиглэгдэж байна. Уг судалгаа нь улирлын байршил, ялангуяа тусгай хамгаалалттай газар нутагт өвлийн саруудад хэрхэн байршдаг нь тодорхойгүй бөхөнгийн хамгаалалд чухал ач холбогдолтой.

Энэхүү мониторингийн хөтөлбөрийн хүрээнд Британийн зөвлөлийн ГҮҮР хөтөлбөрийн санхүүжилтыг ашиглан Юрий Арылов болон Эзэн хааны коллежийн судлаачид хамтран урьдчилсан төслийг эхлүүлсэн. Нүүдэллэдэг зүйлийн судалгаанд анхаарал татаж буй хамтын оролцооны мониторинг нь орон нутгийн мэдлэгийг ашиглах замаар хамгааллын үр нөлөөг үнэлж чадах ба бөхөн хамгаалалд орон нутгийн нөхөрлөлүүдийн оролцоог хангах болно. Бөхөнгийн мониторинг хийх боломж 2010 оны 10 сарын дундаас 2011 оны 6 сарын сүүл хүртэлх хугацаанд 25 ажиглагчийн хийсэн ажлаас үүдэлтэй. Ажиглагчид Степной болон Черные Земли Биосферийн нөөц газарт урдаас хойш чиглэн байрласан бөгөөд 1 ажиглагч нөөц газрын голд байрласан байв (Зураг 1). Өвлийн улиралд (X-II сар) 173 сүргийн 309 бодгаль тэмдэглэгдсэн бол хаврын улиралд (III-VI сар хүртэл) 136 бодгаль тус тус тэмдэглэжээ. Хавар тохиолдсон сүргийн дундаж хэмжээ 107.7) өвлийнхөөс (49.8) том байсан.



Зураг 1. Бөхөн ажиглагчдын бөхөн тэмдэглэсэн байршил. Тоонууд нь тухайн ажиглагчийн харсан бөхөнгийн сүргийн нийт тоог илэрхийлж байна. Черные земли (баруун талд), Степной нөөц (зүүн талд) газрыг нарийн хар зураасаар хүрээлэн тэмдэглэв.

Томоохон сүргүүд II-IV сард ажиглагдсан. Хорин таван ажиглагчаас 24 нь хэдэн бөхөн харсан бөгөөд судалгааны талбайд жилийн туршид бөхөн жигдхэн тархсан байсан.

Тусгай хамгаалалттай газар нутгийн гаднах хэсгийн ажиглалтыг харьцуулахын тулд ажиглагчдыг 2 бүлэгт: тусгай хамгаалалттай газрын хойд хэсэгт байршсан бүлгийг хамарсан нэгдүгээр хэсэг, ТХГ-ын өмнөд хэсэгт байршсан бүлгийг хамарсан хоёрдугаар хэсэг гэж хуваав. Черные земли Биосферийн нөөц газар дахь ажиглагчийн мэдээллийг энэ анализд оруулаагүй тооцсон. Өмнө хэсэг дэхь (175) бөхөн ажиглагдсан тоо нь хойд хэсгээс (109) арай өндөр байв. Нэмж хэлэхэд ажиглалтын явцад харагдсан бөхөнгийн дундаж тоо хойд хэсэгтэй (20.5) харьцуулбал өмнөд хэсэгт (113.6) өндөр байсан. Мониторинг хийсэн талбайн зарим нь давхцсан нь хөрш ажиглагчдын тоо мөн давхцсан болохыг харуулна. Иймээс энэ мэдээлэл нь судалгааны талбай дахь бөхөнгийн популяцийг үнэлэхээс илүүтэйгээр бөхөнгийн харьцангуй нягтшилыг тооцоолон гаргахад ашиглагдах болно.

Эдгээр мэдээлэлийг ашиглан ArcGIS программ дээр өвөл, хаврын улирал дахь бөхөнгийн тархалтын зураглалсан бөгөөд Максент программ дээр Амьдрах орчны тогтворжилтын загварчлалыг бий болгосон. Уг загварчлал нь бөхөнгийн тархалтанд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг танин мэдэхэд ашиглагдсан. Хавраас өвлийн улирал хүртэл бөхөнгийн тархалтын таамаглалд ямар нэгэн ялгаа байгаагүй ба дээрх хоёр улирлын тархалтын загварчлалд ижил хүчин зүйл нөлөөлж байв.

Хавар болон өвлийн улирал дахь бөхөнгийн тохиолдоод нөлөөлж буй үндсэн хүчин зүйл нь тусгай хамгаалалттай нутгаас алслагдсан байдал, усан сан хүртэлх зай байсан бөгөөд усанд ойрхон, нөөц газарт ойр орших нутагт бөхөнгийн харагдах магадлал өндөр байв. Бөхөнгийн тархалтыг жолоодож байгаа тусгай хамгаалалттай нутаг хүртэлх зайн холбогдол нь эерэг болон сөрөг дүгнэлтэнд хүргэнэ. Бөхөн хамгаалагдсан газар нутаг болох Степной болон Черные земли Биосферийн нөөц газар өөрсдийн үйл ажиллагаагаа хэрхэн биелүүлж байгааг илтгэж байна. Хэдийгээр бөхөн тусгай хамгаалалттай газар нутгийн хил дотор болон түүний ойролцоо илүү ихээр тархан байршиж байгаа ч Пре-Каспийн бүс нутагт тулгарч буй асуудал нь хулгайн ан болохыг дахин батлан харуулж байна.

Энэ судалгаан дээр үндэслэн хамтын оролцооны мониторинг нь бидний мэдэж буй бөхөнгийн тархалт, нүүдэллэн шилжих зан төрхийн талаарх ойлголтыг тодорхой болгоход хувь нэмэр оруулах болно. Үнэлгээний тайлан хэлбэрээр хадгалагдах энэ мэдээлэлийг тархалтын цаашдын хандлагыг тогтоох зорилгоор дараагийн мониторингийн үр дүнтэй харьцуулах боломжтой юм.

Устюртын тал нутгийн хүрээлэн буй орчны боловсролд анализ хийх нь

Петер Дамерелл¹, Елена Быкова² Е.Ж. Милнер-Гулланд³

1-Бээжингийн Ой судлалын их сургууль, 2- Узбекистаны Ургамал, амьтны хүрээлэн, 3 –Лондонгийн эзэн хааны коллеж

Харилцах автор: Петер Дамерелл, Peterdamerell@hotmail.co.uk

Устюртын бөхөнгийн популяцийн бууралт үргэлжилсээр байна. Энэ популяцийг тогтворжуулан, тоо толгойг тогтвортой хэмжээнд хүртэл нөхөн сэргээх ажил нь уг зүйлийн мэнд үлдэлтийг эрчимтэй дэмжихэд орон нутгийн хүмүүсийн бэлэн байдал, хулгайн анг эдийн засгийн аргаар таслан зогсоох боломж зэргээс хамаарна. Орон нутгийн нөхөрлөлүүдийг өргөжүүлэн дэмжих нь байгаль орчныг хамгаалах үйлсэд ашиглах зайлшгүй арга хэрэгсэл болсоор байна. Гэсэн хэдий ч өргөжүүлэх хөтөлбөрийн үр нөлөөг тодорхой үнэлэхгүйгээр тэдний хийж чадах ажлын үр дүнгийн тухай нарийвчлан хэлэх боломжгүй юм. Хамгааллын хандлагын ашиг тус, бүтээмжийг дээшлүүлэх боломж нь ялангуяа санхүүжилтын хязгаарлагдмал нөхцөлд үр дүнтэй.

Узбекистаны Устюртын тал нутгийн боловсролын хөтөлбөрийг бөхөнгийн экологи, хамгааллын талаарх хүүхдүүдийн мэдлэг, мэдээллийг сайжруулах зорилгоор 2006 оноос хэрэгжүүлж эхлэсэн. Энэ хөтөлбөр нь Жаслык, Каракалпакия орон нутгийн сургуулиудын хамтын ажиллагаагаар эхлэсэн бөгөөд Кубла-на-Устюрт тосгоныг үүнд хамруулах төлөвлөгөөтэй байна. Бөхөнд суурилсан анги танхимын үйл ажиллагаа нь энэ зүйлийн талаар хүүхдүүд юу сурч мэдсэнийг харах, ангиас гадуурх ажил, үлгэр домог сонсох, бөхөнгийн төлөө тэдний хийсэн ажлыг үнэлэн шагнал гардуулах наадам болох “Бөхөнгийн өдөр”-т бэлдэх чиглэлээр явагддаг (Бөхөнгийн өдөрт зориулсан шинэ мэдээг дээрээс хар). Бөхөнгийн өдөрт хамрагдах орон нутгийн бизнесийн удирдлагууд, бодлого боловсруулагчид, эцэг эхчүүдийн тоо өссөөр байна. Узбекистанд 2011 онд зохиогдсон Бөхөнгийн өдөрт 845 сурагч, 250 орчим эцэг эх оролцсон.

Бид бөхөнгийн талаарх боловсролыг олгодог сургуулийн хүүхдүүдийг (Жаслык болон Каракалпакия тосгоны 2 сургууль), бөхөнгийн боловсролын талаарх ямар нэгэн хөтөлбөр байдаггүй хүүхдүүдтэй (Кубла-на-Устюрт) харьцуулсан. Мөн бид бөхөн хамгаалахад чиглэсэн эцэг эхчүүдийн хандлагыг үнэлсэн.

Боловсролын үйл ажиллагаанд оролцож буй хүүхдүүд, ялангуяа уг хөтөлбөрт хоёроос дээш жил хамрагдсан хүүхдүүд бөхөн, түүний хамгааллын талаар маш сайн мэдлэгтэй болсон байсан. Бид хүүхдүүдийн хамгааллын арга хэмжээний тухай мэдлэгийг шалгахдаа

бөхөнд тулгарч хамгийн их нөлөөлөл бүхий аюул заналыг нэрлэхийг хүссэн. Сургуульд бөхөнгийн талаарх боловсрол олж авсан хүүхдүүдийн бараг тэн хагас нь хүний үйл ажиллагаа бол хамгийн их нөлөөтэй аюул занал гэж үзсэн бол Кубла-на-Устюрт тосгоны хүүхдүүдийн 70 орчим хувь нь гол нөлөөлж буй хүчин зүйл байгалийн хүчин зүйл гэж бодож байсан.

Судалгаанд оролцсон хүүхдүүд 100% боловсролын хөтөлбөрийг маш сайхнаар хүлээн авсан бөгөөд бөхөнгийн боловсрол олгох хөтөлбөр хөгжилтэй байдаг талаар дурдаж байв. Уг хөтөлбөр нь хөгжилтэй бас мэдлэг олгодог гэж хариулсан хүүхдийн тоо энэ бол хөгжилтэй хөтөлбөр гэж энгийнээр тодорхойлсон хүүхдүүдээс хавьгүй илүү байсан. Хөгжилтэй, боловсролын хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцсоноор хүүхдүүд бөхөнд нөлөөлж буй хамгийн том аюул занал нь хүний үйл ажиллагаа болохыг илүү ихээр олж мэдсэн байна.

Дүгнэн хэлвэл судалгаанд хамрагдсан бүлэг, нөхөрлөлүүдийн насанд хүрэгчид бөхөн болон түүний хамгаалал рүү чиглэсэн маш эерэг хандлагатай болсон байсан. Судалгаанд оролцогчид бүгдээрээ “бөхөнг хамгаалах нь эн тэргүүний асуудал биш” гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд 88 % нь бөхөн устаж үгүй болох нь “маш муу зүйл” болохыг эрс шийдэмгийгээр хүлээн авсан (үлдсэн хэсэг нь энэ нь муу зүйл болохыг хүлээн зөвшөөрсөн). Хандлага нь ерөнхийдөө эерэг байсан хэдий ч олонх насанд хүрэгчид өөрсдийн бүлэг нөхөрлөлд байгаа бусад гишүүдийн сөрөг бодлын талаар ярилцаж байв. Гэсэн хэдий ч өөр үзэл бодолтой хүмүүсийн эзлэх




График 1. Бөхөнд тулгарч буй гол аюулын талаарх хүүхдүүдийн ойлголт, тосгоноор

хувь Бөхөнгийн өдөрт оролцсон, эс оролцсоноос хамаарч маш их ялгаатай байв.

Бөхөнгийн өдөрт оролцоогүй насанд хүрэгчдийн бараг 50 хувь нь бусад хүмүүс бөхөн агнахыг хүлээн зөвшөөрч байсан бол энэ хандлага Бөхөнгийн өдөрт оролцогчдын хувьд 0% хүртлээ буурсан байна. Нийт эцэг эхчүүдээс хэрвээ өөрсдийн тосгоны бусад хүмүүс бөхөнгийн мах идэхийг муу зүйл хийсэн гэж бодож байсан эсэх тухай асуухад Бөхөнгийн өдөрт оролцсон эцэг эхчүүдийн 65% нь хүлээн зөвшөөрсөн бол, ердөө 10% нь хамрагдаагүй байна. Сонирхолтой нь дээрх хоёр бүлгийн хүмүүсийн хариулт нь “Би өөрийн тосгоны бусад хүмүүсийн нэгэн адил бөхөн хамгаалахын ашиг тусыг мэдэрч байна” гэсэн тодорхойлолтоос ямар нэгэн байдлаар гажаагүй.

Бөхөнгийн өдөрт оролцоогүй насанд хүрэгчид бүсэд хүмүүсээс арай өөр бодолтой байсан ба тэдний тосгоны бусад хүмүүс бөхөн хамгаалал руу чиглэсэн илүү их эерэг хандлагатай байдаг болохыг батлан харуулсан. Бөхөнгийн өдөрт оролцсоноор насанд хүрэгчдийн нийгмийн хэм хэмжээнд оролцох оролцоо нь бүлэг нөхөрлөлийн эерэг хандлагыг илүү үнэн зөв батлан харуулдаг болохыг бид харсан. Хэрвээ тэд өөрсдийн тосгоны залуусын зохион байгуулсан Бөхөнгийн өдөрт оролцоогүй бол бөхөн агнахын эсрэг үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэхийг ойлгохгүй байх байсан. Бусдын талаар юу гэж бодож байгаа хүмүүсийн ойлголт нь тэдний хувийн зан чанарт хүчтэй нөлөө үзүүлж чадах хүлээн зөвшөөрөгдхүйц арга бөгөөд маш бодитой үр дүн билээ.

Уг судалгааны үр дүн нь Узбекистаны Устюртын тал нутагт хэрэгжүүлж буй боловсролын үйл ажиллагаа нь бөхөнгийн популяцийн бууралтанд хүний үүрэг чухал нөлөөтэй болохыг, мөн хүүхдүүдийн бөхөнгийн тухай мэдлэгийг дээшлүүлэх ач холбогдолтойг харуулж байна. Нэмж хэлэхэд уг боловсролын хөтөлбөр нь бөхөн ашиглалт руу чиглэсэн сөрөг хандлагыг



Зургийг Александр Есинов

Петер Дамерелл ба түүний туслах Жамшид Абатов нар Кубла-Устюрт тосгоны охиноос асуулт асууж байна

өөрсдийн бүлэг, нөхөрлөлд дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх ажлыг дэмжин оролцоход насанд хүрэгчдэд тусалж байна. Энэ нь маш эерэг үр дүн бөгөөд Узбекистанд өргөн тархсан бүлэг нөхөрлөлүүд, хөдөөгийн хүүхдүүдийг сургахаар ажиллаж байгаа тэдгээр хүмүүс өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажил маш чухал нөлөө үзүүлсэн болохыг хараад урам зориг орох болно.

Тус бүс нутагт хэрэгжүүлж эхлэсэн, өргөжсөөр байгаа боловсролын үйл ажиллагаа шиг, бүх хүүхдүүд хөгжилтэй, боловсрол олгох хүчирхэг бүрэлдэхүүн хэсэг бүхий ийм үйл ажиллагаанд оролцон, хүүхдүүд нэг жилээс дээш хугацаагаар оролцох боломжийг хангах нь хүүхдүүдийн сурч боловсрох үйл явцыг нэмэгдүүлж чадна гэдгийг уг судалгааны дүн харуулж байна. Бөхөнгийн өдрийг тосгон даяараа тэмдэглэдэг, насанд хүрэгчид идэвхтэй оролцдог болгон өргөжүүлвэл бөхөн хамгаалахад тэдний үзэл бодол хэрхэн нэгдэж байгаа талаарх ойлголтыг орон нутгийн бүлэг нөхөрлөлд өгөх болно.




График 2. Бөхөнгийн хууль бус ашиглалтын эсрэг нөхөрлөлийн хандлагын тухай шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн насанд хүрэгчдийн ялгаатай тоон харьцаа. Бөхөнгийн өдөрт оролцсон болон оролцоогүй мөн хариулаагүй оролцогчдын тоог мөрөөр харуулсан. Улаан баганаар уг шийдвэрийг зөвшөөрөөгүй хүмүүсийг, ногооноор хариулаагүй хүмүүс, цэнхэр баганаар зөвшөөрсөн хүмүүсийн эзлэх хувийг харуулав.

Иргыз-Тургай-Зыланшик бүс нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ

Алия Телкараева

КБТЗХН, aliya.telkarayeva@acbk.kz

Казахстаны 1,2 сая км² талбайг эзлэн орших хээрийн ландшафтын янз бүрийн хэлбэрт дэлхийд ховордсон ургамал, амьтны зүйлүүд дахин давтагдашгүйгээр оршин амьдарч байна. Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН) нь хээрийн бүсийн биологийн олон янз байдлыг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Өнөөдрийн байдлаар хээрийн бүсийн нийт амьдрах орчны 1,7% нь ТХГН-ийн сүлжээнд орсон байна. Казахстаны засгийн газраас баримталж байгаа 2030 он хүртэл ТХГН-ийн сүлжээг өргөтгөх бодлогын хүрээнд 2010-2014 онд хэрэгжих “Засыл Дами” хөтөлбөрийн хүрээнд ТХГН-ийн сүлжээнд хээрийн экосистем бүхий шинэ газар нутгуудыг нэмж оруулах арга хэмжээ багтана. Даян дэлхийн хүрээлэн буй орчны нийгэмлэгийн “Хээрийн экосистемийн хамгаалал ба тогтвортой менежмент” төсөл ТХГН-ийн сүлжээг бий болгох, хээрийн бүсийн биологийн олон янз байдлыг хамгааллыг дэмжих зорилгоор 2009 онд хэрэгжиж эхлэсэн. Казахстан дахь НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөр дамжин хэрэгжиж буй уг төслийн гүйцэтгэгч байгууллага нь Казахстаны БНУ-ын ХАА-н яамны Ой ангийн салбар зөвлөл юм. Казахстаны биологийн олон янз байдлыг хамгаалах нийгэмлэг нь уг төслийн хамтрагч бөгөөд Казахстаны төв хэсэгт Костанай мужийн 2 засаг захиргааны нэгжийг дамнан 6,2 сая га талбайг эзлэн орших Иргыз-Тургай-Зыланшикийн төсөл хэрэгжих нутагт хээрийн ландшафтын хамгаалал, менежментийн сүлжээг бий болгох зорилготой ажиллаж байна. Хээрийн болон цөлийн ландшафт, усан сүлжээ, намгархаг газрууд байдаг энэ нутагт ховор болон ховордсон хөхтөн, шувуудын зүйл байх бөгөөд Бетпак-далагийн бөхөнгийн популяцийн зуны бэлчээр нутаг болохоос гадна төллөх, нүүдэллэн шилжих гол бүс нутаг юм.

Казахстаны хээрийн бүсийн хамгаалалд байгалийн нөөцийн орон нутгийн ашиглагч нар голлох үүрэгтэй оролцох экологийн коридороор холбогдсон ТХГН-ийн ялгаатай хэлбэр бүхий сүлжээг байгуулах ландшафтын хандлага дээр суурилах болно. Уг нөхцөл нь зэрлэг ан амьтдын байгалийн шилжилт хөдөлгөөнийг хадгалах болно. Энэхүү онцгой тохиолдолд Иргыз-Тургай БНГ болон санал болгож буй “Алтын дала” БНГ-уудыг хамарсан тусгай хамгаалалттай нутаг нь экологийн коридороор холбогдох болно. Ойн ангийн салбар зөвлөлийн шинжлэх ухаан болон технологийн зөвлөлөөс баталсан уг төслийг хэрэгжүүлэхийн тулд бүс нутгийн техникийн болон эдийн засгийн боломжит байдлын судалгааг гүйцэтгэсэн. Костанай мужийн захирагч зайлшгүй хамруулах газар нутгийн чиглэлийг баталсан. Нэмж хэлэхэд бидний судалгаан дээр үндэслэн Иргыз-Тургай БНГ-ыг өргөтгөх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд энэхүү боломжийн талаарх судалгааг гүйцэтгэсэн бөгөөд тухайн газар нутгийг магадлах үйл ажиллагаа явагдаж байна.

Ирээдүйд “Алтын дала” БНГ, Иргыз-Тургай БНГ, Тургай зэрлэг амьтдын нөөц газрын 3 хэсгийг экологийн коридороор

холбохоор төлөвлөгдсөн. Энэхүү коридорт тогтвортой ангийн газар нутаг, зэрлэг амьтдын тогтвортой менежмент бүхий хувийн хамгаалалттай газар, бусад зориулалт бүхий газар нутгуудыг байгуулах болно. Орон нутгийн байгалийн нөөц ашиглагчид, байгууллага, бусад хамтрагч талууд коридор, өөрсдийн ашиглалтыг тодорхойлох үйл ажиллагаанд оролцсон. Экологийн коридорыг байгуулах бодлого нь тухайн экосистемийн нөхцөл, түлхүүр зүйлийн шинжлэх ухааны үндэслэлтэй мониторинг мэдээн дээр үндэслэгдсэн. Янз бүрийн байгууллагаас авсан эдгээр мэдээллийг харьцуулан үзсэн бөгөөд мониторингийн систем нь ирээдүйд хамгааллыг төлөвлөх, ТХГН-ийн менежментийг дэмжихэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

Бөхөн нь коридор болон түүний менежментийн сонголтонд шууд нөлөө үзүүлэх нутгийн түлхүүр зүйл юм. Бөхөнгийн тархалт, нүүдэл шилжилтийн эрчим, чиглэл, хугацааг тогтооход баталгаатай мэдээлэл шаардлагатай. Зөвлөлт засгийн үеэс цуглуулагдан ирсэн түүхэн мэдээллийг бөхөнгийн амьдрах орчин их хэмжээгээр өөрчлөгдөн, бага тоогоор сүрэнгэлсэн үед тэдгээрийн зан төрхийн онцлог илт ялгаатай болж эхлэсэн үеэс хэрэглэж болохооргүй болсон. КБТЗХН-ийн мэргэжилтнүүд 2008 оны 4 сараас эхлэн бөхөнгийн ажиглалтыг гүйцэтгэж байгаа бөгөөд Ой ангийн зөвлөлөөс жил бүр зохион байгуулдаг агаарын тооллогод оролцдог. Сансрын дохиололтой хүзүүвч зэрэг дэвшилтэт технологийг ашиглаж байна. Эдгээр мэдээлэл нь эн тэргүүнд хамгаалах шаардлагатай газар нутгийн холбон загварлал бий болгох, ландшафтын түвшинд экологийн үйл явцыг үнэлэхэд ашиглагдана.


Экологийн коридорыг төлөвлөх эхний алхам нь рельеф болон хөрсний бүтцээс хамаарах ургамлын бүлгэмдлийн тохиолдоцыг тусгасан экологийн бүсийн суурь мэдээллийг цуглуулах ажил юм. Ландшафтын газрын зурагт ховор амьтан, ургамлын тохиолдоц, ус, түймэр, нийгэм эдийн засгийн хүчин зүйл зэргийг хамруулна. Төсөл хэрэгжих газар нутаг: 1) харьцангуй тогтвортой байдал, 2) экологийн риск, 3) экологийн аюул занал дээр үндэслэгдэнэ. Ирээдүйд сөрөг үр дагавар бүхий үйл ажиллагаа саармагжин багасах, эсвэл шинэ аюул занал урган гарч ирэх бөгөөд бүс нутгийн хил хязгаар өөрчлөгдөх болно. Төсөл хэрэгжих бүс нутаг дахь экологийн мониторинг нь 2009-2011 оны хооронд ургамал судлаач, шувуу судлаач, амьтан судлаач, GIS мэргэжилтэн, ландшафтын экологич, цаг уур судлаачдыг оролцуулан өргөн хүрээтэй хийгдсэн. Цуглуулагдсан шинэ суурь мэдээллийг экосистем болон тэдгээрийн ялгаатай бүрдэл хэсгүүдийн цаашдын мониторингийг бий болгоход ашигласан. Мониторинг мэдээллийн санг үүсгэсэн.

Уг төслийн 2 дахь шат нь хил хязгаарын тодорхойлолтын шалгуур, төлөвлөгөөг сонгох байсан.

Гол нөлөөтэй хүчин зүйл нь анхаарал хандуулж буй зүйлийн амьдрах орчны байгалийн хил хязгаар; ландшафтын ялгаатай хэлбэрүүдийн тохиолдоц; байгалийн ургамлан бүрхэвчийн нөлөөлөлд өртөөгүй байдал; хүн амын суурьшил бүхий газраас алслагдсан байдал; усан хангамжийн хүрэлцээ; ургамжилтын индекс утга; биологийн олон янз байдлын түвшин зэрэг байсан.

Гуравдахь буюу эцсийн шат нь экологийн корридорын хил хязгаарыг цуглуулагдсан мэдээлэл болон зорилго дээр үндэслэн уг корридорын хамгийн тохиромжтой хослолыг олохын тулд GIS, MARXAN программ хангамж ашиглан газрын зураг дээр тодорхойлох, дүрслэх байсан. Энэ бүх нийлмэл, өргөн хүрээтэй ажил нь ТХГН-ийн сүлжээ,

экологийн корридорыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бий болгоход бидэнд туслах болно. Бидний цаашдын зорилго бол дээрх бүх сүлжээний хэсгүүдийг Улсын тусгай хамгаалалтанд хамруулах бөгөөд ингэснээр уг сүлжээ үр өгөөжтэйгээр ажиллаж чадна.



Зураг.

MARXAN программ ашиглан боловсруулсан экологийн корридор

Устюртын талд баригдаж буй хилийн торны хэрэгжилтийн явц, бөхөнг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах боломжууд

Е.Ж. Милнер-Гулланд

Лондонгийн эзэн хааны коллеж, Бөхөн хамгаалах нийгэмлэг, e.j.milner-gulland@imperial.ac.uk

1990-ээд оны дунд үед 250000 бодгальтай гэж үнэлэгдэж байсан Устюртын бөхөнгийн популяци бусад популяцийн нэгэн адил 2000 оны эхэн гэхэд тоо толгойн хэт бууралтанд орсон байв. Хэдийгээр Казахстаны бусад популяцитай адил бус ч Устюртын популяцийн тоо толгойн бууралт үргэлжилсээр, хамгийн бага хэмжээ нь 2010 онд хийгдсэн Казахстаны агаарын тооллогоор 4900 болсон бөгөөд хамгийн сүүлчийн тооллогын үр дүнд 6500 бодгалиар үнэлэгдэж байгаа нь бөхөнгийн нийт популяцийн хувьд харьцангуй бага тоо юм.

Энэхүү популяцийн нөхөн сэргэх үйл явц удаашралтай байгаад нөлөөлж буй гол хүчин зүйл нь өнөөгийн судалгааны дүнд батлагдсан Казахстан, Узбекистанд хийгдэж байгаа арилжааны зориулалттай ан агнуур юм. Сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгааны явцад орон нутгийн хүмүүсийн Устюртаас Казахстангаар дамжин Хятад руу чиглэсэн худалдааны зам байгааг тогтоосон бөгөөд бөхөнгийн популяци орон нутгийн хэрэглээнд махыг, олон улсын худалдаанд эврийг арилжаалах зорилгоор агнагдсаар байгааг нотолж байна. Устюртын популяцийн хил дамнан байршиж байгаа нь, ялангуяа Казахстан (зун), Узбекистаны (өвөл) хооронд улирлаар шилжин байршиж буй популяцийн томоохон хэсгийг хянахад хүндрэл учруулж байна. Хамтын оролцооны мониторинг нь Узбекистанд бага тоотой боловч бүтэн жилийн туршид бөхөн

байршиж байгааг нотолсон. Казахстаны бүх бөхөнгүүд хил огтлон нүүдэллэдэггүй ч гэсэн популяцийн дийлэнх хэсэг 2 улсын хооронд нүүдэллэж байна.

Бүс нутгаас авсан сүүлийн үеийн мэдээгээр Казахстан, Узбекистаны хооронд баруунаас зүүн тийш чиглэсэн торон хашаа бараг дуусаж байгааг харуулж байна (хавсаргасан зургийг шинэ мэдээний дээд талаас харна уу). Энэхүү мэдээлэл нь уг өргөст торон, өндөр хашаа нь бөхөн гарч чадахгүй болохыг илтгэнэ. Иймд Устюртын бөхөнгийн популяцид нүүрлэж буй энэхүү хашааны нөлөө ямар байх вэ?

Бөхөнгийн нүүдэл нь уг нутгийн хүрээлэн буй орчны хатуу ширүүн нөхцөлд дасан зохицох үзэгдэл бөгөөд ихэнх судалгааны үр дүнд хатуу ширүүн өвлөөс зугтаах зан төрх нь тэднийг тархац нутгийн хойд хэсэг рүү буюу зуны туршид маш сайн бэлчээртэй байсан газар луу нүүдэллэхэд хүргэдэг болохыг нотолсон. Нүүдэллэх үзэгдэл нь дэлхийд бараг устаж байгаа бөгөөд бөхөн нь популяцийн асар их бууралтыг тэсвэрлэн, энэхүү зан төрхийг харуулсаар байгаа цөөн хэдэн нүүдэллэдэг зүйлийн нэг билээ. Иймээс нүүдэл нь бөхөнгийн агуу их уян хатан чанар, тэдгээрийн нөхөн сэргэх эрч хүчийг харуулсан гол хүчин зүйл болохыг харуулна. Энэхүү нүүдэл шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх аливаа саад тогтор нь урт болон богино хугацааны үр нөлөөтэй.

Нүүдэллэдэг зүйлүүдэд учруулж буй хашааны нөлөөг судалсан бусад орны тушлага дээр тулгуурлан, мөн 1970 онд тэдний нүүдлийн замд байгуулсан суваг бөхөнгийн популяцид их хэмжээний үхэл хорогдол учруулсан туршлагад тулгуурлан бөхөн хашааг давж гарахаар оролдох ба энэ явцад үхэх, эсвэл стресст орох, гэмтэл авах зэргээр богино хугацаанд нөлөөлнө гэдгийг бид таамаглаж байна. Хашаанд тулсан бөхөнгийн бөөгнөрөл нь хулгайн анчдад хялбар олз болох болно. Энэ үхэл хорогдол нь аль хэдийнээ үгүйрэн хоосорсон популяцийг нилээд хэмжээгээр бууруулах шалтгаан болох бөгөөд энэ жилээс ажиглагдаж эхэлж байна.

Урт удаан хугацаанд нүүдлийн замын дагуух саад нь Устюртын популяци болон Узбекистан дахь бага нягтшилтай тусгаарлагдсан популяцийн нөхөн үржлийн чадавхийг бууруулах бөгөөд Казахстан дахь эх популяци өвлийн бэлчээрт хүрэх боломжгүй болно. Бөхөнгийн бусад популяцийн шилжилт хөдөлгөөн сүүлийн жилүүдэд буурсан эсвэл тэдгээрийн шилжилт хөдөлгөөн (өөрөөр хэлбэл Пре-Каспийн болон Монголын популяци) Устюртийн популяцийн шилжилт хөдөлгөөн шиг эрчимтэй байгаагүй. Хашаа нь популяцийг устгах чиглэлд хөтлөх бөгөөд богино хугацааны үхэл хорогдлын дараа популяци мэнд үлдэх нь эргэлзээтэй харагдана. Эсрэгээрээ нүүдлийг багасгах, алга болгох шалтгаан болохоос гадна хорин жилийн өмнөх хэмжээнд хүрэх боломжийг үгүй хийх болно.

Дэлхийн том туруугны нүүдэл нь гайхамшигт үзэгдэл, ургамал болон хөрсний динамик хувиралд нөлөөлдөг, тэнд байх ургамал, амьтны зүйлийн олон янз байдал, бүтцийг тодорхойлдог экосистемд үзүүлэх нийлмэл хүчний түлхүүр юм. Иймээс тэнд хашаа барьснаар Устюртын экосистем өөрчлөлтөнд орох боломжтой юм. Тиймээс юу хийж чадах вэ? Байгаль хамгааллын асуудлыг тооцож үзэлгүйгээр улс төрийн харалган шийдвэрийн нэг болох хилийн торон хашааг хэвээр үлдээсэн.




Амьтан хашааг аюулгүйгээр гаталж байгаа нь [Кирк Олсоны авсан зураг]

Гэвч засгийн газрын байгууллагууд оролцон торон хашааны боломжит үр дагавар, нөлөөллийг бууруулах арга замууд, боломжийн талаархи мэдээлэл цуглуулах хэрэгтэй бөгөөд ингэснээр Устюртын бөхөнгийн популяцийн шилжилт хөдөлгөөн аль болох саадгүйгээр үргэлжлэх болно. Үүнийг тодорхойлохын тулд олон орноос нилээд их туршлага хуримтлуулсан. Тархац нутгийн хаа нэгтээ ашиглагддаг өндөр өртөгтэй, техникжсэн аргаас эхлээд маш энгийн, хямд өртөгтэй арга замууд байдаг. Энгийн, үр дүнтэй аргын жишээг доорхи зургаар харуулав. Хамгийн доод талын өргөст төмөр утсыг өргөсгүй утсаар солин сул ороон татах бөгөөд хашаанд нүүдэллэж буй амьтанд харагдахуйц ямар нэгэн туг эсвэл тууз хийх хэрэгтэй.

Хашааг барьж дууссанаас хойш хэдэн сарын дараа бөхөнгийн өвлийн нүүдэл эхлэх ба энэ асуудлыг засгийн газрын дээд түвшинд яаралтай танилцуулж хэлэлцүүлэн шийдвэрлэх ёстой чухал асуудал бөгөөд ингэснээр шийдвэр аль болох түргэн хугацаанд гарна.

Эсрэг тохиолдолд бид дэлхий дээрх *S. t. tatarica*-гийн дөрвөн популяцийн нэгийг устгасны гэрч болох магадлалтай юм. Юу ч болсон гэсэн энэ шийдвэрлэх мөч нь хуулийн үр нөлөөтэй хэрэгжилт, олон нийтийн оролцоо, сурталчилгаа, тусгай хамгаалалттай газар гэх мэт хилийн хоёр тал дахь Устюртийн популяцийн цаашдын хамгааллын менежментэд шаардлагатай зүйлсэд анхаарлаа хандуулах хэрэгтэй.



Нүүдэллэдэг амьтанд гэмтэл байга учруулах энгийн хашааны загвар [Кирк Олсоны авсан зураг]

Бөхөнгийн баатрууд



Алдартай амьтан судлаач, Казахстаны ШУА-ийн гишүүн Аркадий Александрович Слудскийгийн мэндэлсэний 100 жилийн ой 2012 оны 2 сард тохиосон. Тэрээр Казахстаны сээр нуруутан амьтдын судалгааг үндэслэсэн бөгөөд Амьтан судлалын хүрээлэнгийн Хөхтөн амьтны лабораторийг үүсгэн байгуулж, 1949-1977 оны хооронд эрхлэгчээр ажиллаж байсан. Түүний амьтан судлалын сонирхол маш өргөн хүрээтэй байсан боловч бөхөн нь түүний судалгаанд чухал байр суурь эзэлж байв. Гарамгай бөхөнгийн биологич Юрий Грачев Бөхөнгийн мэдээний энэ дугаарын Бөхөнгийн баатраар А.А.Слудскийг сонгосон.

Слудскийгээс өмнөх үед бөхөнтэй тааралдсан тухай болон бөхөнгийн эврийн худалдааны мэдээлэл тойм төдий, экспедицийн явцад цуглуулсан хэсэг бусад тоо байсан. Судалгааны ажил 1940-өөд оноос, ялангуяа 1950 оны эхэн үеэс эрчимтэй явагдаж эхлэсэн. Энэ үетэй давхцан 20 зууны эхэн үед эмзэг түвшинд очоод байсан популяцийн бууралтыг дагасан удаан хугацаанд үргэлжилсэн зогсонги үеийн дараа тоо толгой нь нөхөн сэргэж байсан бөгөөд бөхөнг ашиглах асуудал хүчээ авч байсан. Аркадий А.Слудский өөрийн судалгаан дээр үндэслэн Зөвлөлт социалист Казахын БНУ-ын сайдын зөвлөлд зориулан тайлан бэлдэж байв. Казахстанд 1954 оноос бөхөнгийн худалдааг зөвшөөрөн лицензтэй болгосон. Дараагийн 40 жилд бөхөнгийн худалдаа улсад ихээхэн ашиг авчирсан бөгөөд Слудский 1983 онд бусад биологичдын хамт бөхөнг тогтвортой ашиглах биологийн зарчмыг бий болгосон учраас Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Казах улсын төрийн шагнал хүртсэн.

1950 оны эхэн үе хүртэл хийгдсэн Слудскийн судалгааны ажил нэгтгэгдэн “Казахстаны бөхөн” (1955) нэртэй өгүүлэл болон хэвлэгдсэн. Энэ өгүүлэлд өнгөрсөн болон одоогийн тархац нутаг, улирлын байдлаар Казахстанд байршин нутаглах бөхөнгийн тоо, нягтшил зэрэг асуудлыг хамруулан нарийвчлан бичжээ. Мөн уг өгүүлэлд бөхөнгийн нөөцийн менежментийн биологийн зарчмууд, бөхөн агнуурын бизнес менежмент, зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, цаашдын шинжлэх ухааны судалгаанд юу хэрэгтэй байгаа талаар хөндсөн байна.

Зургийг Казахстаны Амьтан судлалын хүрээлэнгийн архиваас



Бетпак-далагийн бөхөнгийн экспедици, 1956

болох нь 1970 онд чонын тоо толгой өсөхтэй зэрэгцэн бөхөнгийн тоо толгойн өсөлт бараг арав гаруй жил ажиглагдсанаар батлагдсан.

Түүний бусад суурь ажлуудын нэг нь “Евроазийн хээр болон цөлийн бүсийн зуд” ном бөгөөд Слудский бөхөн зэрэг зэрлэг амьтад болоод гэрийн малд байгаль цаг уурын тохиромжгүй нөхцлийн нөлөөллийг авч үзжээ. Тэрээр тэжээлийн хомсдол, сульдах, туурган амьтдын их хэмжээгээр үхэж хорогдох үзэгдэл нь Евроазийн хээр болон сэрүүвтэр цөлийн бүс нутагт өвлийн улиралд түгээмэл тохиолддог болохыг харуулсан. Тэрээр зуданд дасан зохицох нөхцлийг (өвлийн хатуу ширүүн цаг уурын нөхцөлд дасан зохицоогүйн улмаас бөөнөөрөө үхэж хорогдох) дүгнэсэн бөгөөд 10-аас дээш, зуугаас хэдэн мянган амьтад үхэж хорогдсон баримт нотолгоог гаргаж ирсэн. Слудский өвлийн улиралд бөхөнгийн дасан зохицох онцлог



Зургийг Казахстаны Амьтан судлалын хүрээлэнгийн архиваас

Бөхөнгийн сүрэг гол хөндлөн гарч байгаа нь

болох биесийн өнгө бараанаас цагаан хүртэл өөрчлөгдөх, өөх хуримтлуулах, цас ухан идэш тэжээлээ олж идэх чадвар, бөөнөөрөө сүрэглэх хэлбэр, бусад туруутан амьтадтай хамт идээшлэх болон нүүдэл зэргийг тодорхойлсон.

Аркадий А.Слудскийгийн санаачилгаар бөхөн рүү чиглэсэн хээрийн судалгааны хөтөлбөр 1965 онд хэрэгжиж эхлэсэн бөгөөд уг хөтөлбөрт жил тутам агаарын тооллого судалгаа хийх, идэш тэжээл, нөхөн үржил, шилжилт хөдөлгөөн, өвчин эмгэг, шимэгч зэрэг экологийн судалгааны асуудлууд багтаж байв. Бөхөнг зүй зохистой ашиглах санал зөвлөмжүүд нь засгийн газрын байгууллагуудад жил бүр танилцуулагдан, практикт хэрэглэгдэж байв. Энэхүү урт хугацааны судалгааны хөтөлбөрийн дүнд (1965-1981 он хүртэл) Казахстаны бөхөнгийн экологийн талаарх асар их мэдээ, хэрэглэхүүн цуглуулсан бөгөөд эдгээрийг “Казахстаны бөхөн” (Фадеев, Слудский, 1982) гэсэн нэг сэдэвт бүтээлд нэгтгэн дүгнэсэн. Слудский судалгаа шинжилгээний ажилд өөрийн биеэр оролцож байсан бөгөөд уг бүтээлийг хамтран бичиж байсан боловч харамсалтай нь номоо бүрэн дуусгаж чадалгүй зуурдаар хорвоогоос хальжээ.

А.А.Слудскийгийн эхлүүлсэн судалгааны ажил дараагийн 10 жилд үргэлжилсэн. Энэхүү ажлын үр дүн 1998 онд хэвлэгдсэн ном болох “Бөхөн:филогени, ангилал зүй, экологи, хамгаалал ба ашиглалт” (Соколов, Жирнов нарын хянан тохиолдуулсан), 1998 онд хэвлэгдсэн “Казахстаны бөхөнгийн экологи ба менежмент” (бекенов нарын бичсэн) нэртэй өгүүлэл болон бусад бүтээлд тусжээ. А.А.Слудскийгийн хүсэл мөрөөдөл нь бусад зүйлийн ихэнх амьтад дээр дутагдалтай байсаар байгаа ач холбогдолтой, үд давтагдах урт хугацааны мэдээллийн бааз суурийг бүрдүүлж өгсөн нь одоо бид яагаад бөхөнгийн экологийн талаар ойлголтын хүчирхэг бааз суурьтай байгаагийн шалтгаан юм.



Зургийг Казахстаны Амьтан судлалын хүрээлэнгийн архиваас

Аркадий А. Слудский бөхөнгийн янзага барьж байгаа нь, 1967 он

Редакторын тэмдэглэл: Сэтгүүлийн дугаар бүрийг бид бөхөн хамгаалалд асар их хувь нэмэр оруулж буй хүмүүст зориулж байна. Эдгээр хүмүүс дэлхийн өнцөг булан бүрт, амьдралын янз бүрийн хэв маягтай хүмүүс боловч, тэд энэ зүйлийг хамгаалах өөрсдийн хүсэл тэмүүллийг нэгтгэсэн. Хэрвээ та Бөхөнгийн мэдээ сэтгүүлийн дараагийн дугаарт Бөхөнгийн баатраар нэрээ оруулахыг хүсэж байвал редактортай esipov@xnet.uz хаягаар холбогдоно уу.



Уст цэг дээрх бөхөнгийн сүрэг

Талархал

Бөхөн хамгаалах нийгэмлэг сүүлийн 6 сарын туршид бидний үйл ажиллагааг дэмжсэн дараах хувь хүмүүст: Жой Совей болон түүний хүү Тайлор Герсте, Кеннон болон Боб Худсон, Стуфф & ПееВее Маршалл, Карролл Анн Нодгес, Николас Гонзалез & Гонзалезийн гэр бүлийнхэн, Жоан Бридгвүүд, Дебора Чиорнеко, Петер Желинек, Ринат Абдрашитов, Жосеф Алфано, Брусе Капрон болон Патрика Вүүд нарт чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна.

Бид Узбекистаны бөхөнгийн тархац нутаг дахь бидний боловсрол олгох болон мониторинг судалгааны хөтөлбөрийг дэмжиж санхүүжүүлсэн Байгаль болон Дисней Онлайн студийн Витлей сан, Дисней Канада, холбооны хэрэгслээр хангасан Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенци, бидний хэрэгжүүлж буй олон улсын болон бүс нутгийн хөтөлбөрийг дэмжин ажиллаж байгаа Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний хамт олонд гүн талархлаа илэрхийлж байна. Мөн сэтгүүлийн шинэ дугаарыг ивээн тэтгэсэн байгууллагууд болох Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газарт талархаж байна.

Редакцийн зөвлөл. Хятад: А. Канг (akang@wcs.org) & Фенглиан Ли (fli@wcs.org) WCS China; Казахстан: Профессор А. Бекенов & док Ю.А. Грачев, Зоологийн хүрээлэн (terilogi@mail.ru), О. Климанова, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (olga.klimanova@acbk.kz); Монгол: доктор Б.Лхагвасүрэн & Б. Чимэддорж, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар (lkhagvasuren@wwf.mn; chimeddorj@wwf.mn); ОХУ: Профессор Ю. Арылов, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан судлах төв (kalmsaigak@elista.ru) & док А. Лущекина, Экологи эволюцийн хүрээлэн (gusmabcom@gmail.com); Узбекистан: Е. Бикова [Гүйцэтгэх редактор] & док А. Есипов, Амьтан, ургамлын генийн сангийн хүрээлэн (esipov@xnet.uz); Их Британи: Профессор Е.Ж. Милнер-Гулланд [зөвлөх редактор], Лондонгийн эзэн хааны коллеж (e.j.milner-gulland@imperial.ac.uk).

Бүх өгүүллийг бидний хэрэглэдэг 6 хэлний аль нэг дээр бичнэ үү. Өгүүллийг esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын аль нэг рүү илгээнэ үү. Бид жилд хоёр удаа гаргадаг. Материалаа esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын хэн нэгэнд илгээнэ үү. Сэтгүүл жилд хоёр удаа гардаг. Өгүүлэл бичих журмыг www.saiga-conservation.com хуудсаас эсвэл редакторуудаас англи болон орос хэл дээр авч болно. Хэрвээ танд асуулт гарвал өөрийн улсын Бөхөнгийн мэдээний редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай (esipov@xnet.uz) холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр www.saiga-conservation.com, <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/mini/saiga-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар, эсвэл хүсэлтийн дагуу сэтгүүл хэлбэрээр редакторуудаас англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр авч болно.